

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 41

- Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар*
1. байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох төрийн
байгууллагуудын мэдээллийг сонсох

4 – 41

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын болон Инновац, цахим бодлогын
байнгын хороодын 05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн хамтарсан хуралдааны
товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 36 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Э.Батшугар, Э.Болормаа, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхбат, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Э.Одбаяр, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Ө.Шижир.

Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн дарга Н.Баясгалан, Төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны хуульч Ц.Номин, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын захирал Б.Хосбаяр, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны дарга С.Тэнгис, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын дарга Э.Түвшин, мөн газрын Салбарын шинэчлэл, бизнесийн орчныг дэмжих хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Золзаяа, Үндэсний статистикийн хорооны Мэдээллийн технологийн газрын дарга Ц.Эрдэнэмөнх, Үндэсний аудитын газрын Чанарын удирдлагын газрын захирал Ж.Батсайхан, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын Программ хөгжүүлэлт, чанарын удирдлагын хэлтсийн захирал Ц.Тамир, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын программ хангамжийн инженер Б.Анударь, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, “Ухаалаг засаг-2” төслийн зохицуулагч зөвлөх Э.Цогбаяр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн О.Сүлд-Өрлөг, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн М.Лхагважав, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Манлай нар байлцав.

Үндэсний статистикийн хорооны мэдээллийг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Үндэсний аудитын газрын мэдээллийг Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Монголбанкны мэдээллийг Монголбанкны Мэдээллийн технологийн газрын захирал Б.Хосбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн мэдээллийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны дарга С.Тэнгис, Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар нар танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны дарга С.Тэнгис нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Цэнгүүн, Б.Хэрлэн, Ч.Анар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 36 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 00 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг айлтгая.

Төрийн байгуулалтын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаан эхэлж байна.

Хуралдааны ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Ж.Золжаргал, Ч.Номин, Ц.Сандаг-Очир, Л.Энх-Амгалан, Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, С.Баярцогт, С.Зулбахар, О.Номинчимэг, Ч.Ундрэм, Ч.Анар, Б.Баярбаатар, Ж.Галбадрах, Т.Мөнхсайхан, Б.Пүрэвдорж, Г.Уянгахишиг нарын гишүүн хүрэлцэн ирж 52.8 хувийн ирцтэй болсон байна. Ирц танилцуулж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт гишүүн ирцэд орсон байгаа. Нэр буруу дуудсан тул залрууллаа.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Санал байхгүй байна.

Хэлэлцэх асуудалд орё.

Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл өгөх ажлын хэсгийг танилцуулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Үндэсний статистикийн хорооны

Мэдээллийн технологийн газрын дарга Ц.Эрдэнэмөнх, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Чанарын удирдлагын газрын захирал Ж.Батсайхан, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын захирал Б.Хосбаяр, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын Программ хөгжүүлэлт, чанарын удирдлагын хэлтсийн захирал Ц.Тамир, Монголбанкны Мэдээллийн технологийн газрын программ хангамжийн инженер Б.Анударь, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын дарга Э.Түвшин, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын Салбарын шинэчлэл, бизнесийн орчныг дэмжих хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Золзаяа, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, “Ухаалаг засаг-2” төслийн зохицуулагч зөвлөх Э.Цогбаяр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн О.Сүлд-Өрлөг, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн М.Лхагважав, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Манлай, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн дарга Н.Баясгалан, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны дарга С.Тэнгис, Төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны хуульч Ц.Номин. Ийм бүрэлдэхүүнтэй ирсэн байна.

Ингээд дарааллын дагуу эхлээд Үндэсний статистикийн хорооны мэдээллийг Үндэсний статистикийн хорооны дарга Батмөнхийн Батдаваа хийнэ.

Б.Батдаваа дарга мэдээлэл хийнэ үү. Хэддүгээр микрофон дээр байгаа билээ? Гол руу суугаад. 6 дээр суучих уу? 6 дугаар микрофон нээж өгье.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооноос үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, технологийн дэвшлийг ашиглах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаас товч танилцуулъя.

Нэгдүгээрт, бид үйл ажиллагаагаа Нэгдсэн Үндэстний Байгууллагаас санал болгож буй статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд статистикийн бизнес процессыг дахин төлөвлөж,

мэдээлэл цуглуулалтаас тархаалт хүртэлх бүх үйл ажиллагааг цахимжуулсан статистикийн үйлдвэрлэлийн системийг нэвтрүүлсэн болно.

Хоёрдугаарт, дотоод үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, статистикийн мэдээлэл цуглуулалтыг хянах цахим системүүдийг ашиглалтад орууллаа. Ингэснээр энэхүү системүүдээс үүссэн өгөгдөлд үндэслэн мэдээллийн чанарыг сайжруулах төсөв, цаг хугацааг хэмнэж байна.

Гуравдугаарт, үндэсний өгөгдлийн замын зураглалыг боловсруулж, төрийн зарим байгууллагын мэдээллийн санг нэгтгэж, төрийн нэгдсэн өгөгдлийн сан болон төрийн мета өгөгдлийн нэгдсэн сангийн цахим талбаруудыг ашиглалтад оруулсан.

Эдгээр цахим талбаруудын мэдээлэл тулгуурлан хэрэглэгчид олон хэмжээст нарийвчлал бүхий өгөгдөл ашиглан шийдвэр гаргах, судалгаа, шинжилгээ хийх боломжтой болж байна.

Дөрөвдүгээрт, бид 2024 онд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Ингэснээр статистикийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагад нэг шат ахилаа гэж бид үзэж байгаа.

Тавдугаарт, бид хэрэглэгчдэд статистик мэдээллийг хялбар хүргэх зорилгоор хиймэл оюунд суурилсан чатботыг статистикийн мэдээллийн нэгдсэн санд туршилтын байдлаар өнгөрсөн оны эцэст нэвтрүүлсэн.

Зургадугаарт, сансрын зураг, их өгөгдөл статистикт ашиглах зорилгоор бид туршилт судалгаануудыг хийж, зарим салбарт эдгээр шинэ технологийг ашиглаж эхэллээ. Тухайлбал, өмнө нь аж ахуйн нэгж, байгууллагуудаас цаасан хэлбэрээр авдаг байсан зарим судалгааг бид төрийн байгууллагуудын мэдээллийн сан болон их өгөгдөлд суурилан боловсруулдаг болоод байна.

Долдугаарт, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хүн ам, орон сууцын завсрын тооллого, аж ахуйн нэгжийн тооллогыг төрийн байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан жил болгон цахим хэлбэрээр явуулах тогтоолыг бид батлууллаа.

Ингэснээр цаашид Монгол Улсын хүн амын тооллого буюу хүн ам, өрхийн нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй судалгааг бид жил болгон бүрдүүлэх цахим орчин дэд бүтцийг бий болгож, цаашид уламжлалт тооллогод зарцуулдаг төсөв, цаг хугацаа хэмнэх, мэдээллийн бэлэн байдал, давтамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөгжүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын статистикийн систем нь

- ▶ Мэдээллийн хамрах хүрээ, нээлттэй байдлын үнэлгээгээр дэлхийд 11 дүгээр байрт, Зүүн Азид 2 дугаарт,
- ▶ Дэлхийн банкны гүйцэтгэлийн үнэлгээгээр Зүүн Ази, Өмнөд Ази, Номхон далайн орнуудаас 7 дугаар байрт, дэлхийд 51 дүгээр байрт,
- ▶ Дэлхийн эдийн засгийн байгууллагын үндэсний тооцооны өгөгдлийн чанарын үнэлгээгээр Ази, Номхон далайн улсуудаас 9 дүгээр байрт, дэлхийд 49 дүгээрт,
- ▶ Хүн амын статистикийн чанарын үзүүлэлтээр Ази, Номхон далайн улсуудаас 8 дугаар байрт, дэлхийд 25 дугаарт эрэмбэлэгдэж байгаа.

Бид Монгол Улсын статистикийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран цогц үнэлгээ хийж, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг мөн зохион байгуулж байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын статистикийн системд олон улсын болон гадаад улсын байгууллагуудаас хийсэн дээрх үнэлгээнүүд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн бид мэдээллийн чанар, нарийвчлал, үйл ажиллагаа, хамрах хүрээ, бэлэн байдал, эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа болно.

Анхаарал хандуулсан Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэнд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хоёр дахь танилцуулгыг явуулъя.

Үндэсний аудитын газрын мэдээллийг Монгол Улсын ерөнхий аудиторовн орлогч Занданбазарын Цэдэнжав. 9 дүгээр микрофон.

3.Цэдэнжав: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Үндэсний аудитын газраас бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор процессын дахин инженерчлэл хийж байгаа асуудлаар товч мэдээлэл хүргэе.

Аудитын дээд байгууллагуудын хувьд үйл явцыг дахин загварчлах үйл ажиллагаа нь байгууллагын ил тод байдал, хариуцлагатай байдлыг

нэмэгдүүлэх, сайн засаглалыг хангах, аудитын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж бид үзэж байгаа.

Үндэсний аудитын газраас бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн аудитын үйл явцын өөрчлөлтийг удирдах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулж өгсөн.

Мөн 2020 онд Төрийн аудитын хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах, мэдээллийн эх кодтой ажиллах, мэдээллийн технологийн аудит хийх ажиллагааг хуульчилж өгсөн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Төрийн аудитын байгууллага эдгээр хууль эрх зүйн боломжуудыг ашиглан цахим технологи, мэдээллийн аудитын үйл ажиллагааг ашиглах үйл ажиллагааг 2021 оноос эхлүүлсэн.

Одоогоор мэдээллийн 12 системийг бид ашиглаж ажиллаж байгаа.

Бодлого стандарт, арга зүйн шинэчлэлийн хүрээнд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхээс гадна аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагаас баталсан стандартын дагуу явагддаг.

Аливаа аудитын үйл ажиллагаа төлөвлөлтийн үе шатаас эхлээд тодорхой стандартын шаардлагыг хангаж явах хараат бус үйл ажиллагаа.

Төрийн аудитын тухай хууль дээр төрийн аудитын зарчимд төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх, төрийн аудитын байгууллагаас батлан гаргасан стандартаа мөрдөх, аудитын дээд байгууллагын олон улсын хүлээн зөвшөөрсөн стандартуудыг бид хэрэглэж ажиллаж байгаа.

Энэ хүрээнд Төрийн аудитын стандартын хороо Монгол Улсын ерөнхий аудиторроос олон улсын аудитын байгууллагын 10 гаруй стандартыг нутагшуулж бид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байгаа болно.

Хамгийн сүүлд бид 2025 онд аудитын чанарын удирдлагын тогтолцооны стандартыг боловсруулж баталж хэрэгжүүлсэн. Энэ стандарт бол төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагааны загварыг шинэчлэх, тогтолцоогоо шинэчлэх чухал арга хэмжээ болж байгаа.

Төрийн аудитыг “чанарын хяналт”-аас бид “чанарын удирдлага”-ын тогтолцоо руу шилжүүлэх процессыг эхлүүлээд ажиллаж байгаа.

Энэ ажлын хүрээнд манай дээр Олон улсын аудитын дээд байгууллагын хөгжлийн санаачилгаас тодорхой зөвлөмжүүд, гарын авлагуудыг, удирдамжийг авч бид өөрийн бүх үйл ажиллагаа, процессоо үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Төрийн аудитын байгууллагад 2025-2030 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн баталсан.

Ингэхдээ бид Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө болон Аудитын дээд байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан баталсан. Ингэж батлахдаа орчин үеийн хөгжлийн чиг хандлага болон цахим шилжилтийг аудитын үйл ажиллагаанд оруулах үйл ажиллагаанд бид анхаарч ажилласан. Тодорхой тэргүүлэх чиглэлүүдээ энд анхаарч ажиллаж байгаа.

Бид удахгүй аудитын үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавхаа дээшлүүлэх, аудитын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор цахим аудитын платформ тогтолцоо руу шилжих энэ ажлыг эхлүүлээд ажиллаж байгаа.

Мөн Монгол Улсын Их Хурлаас бас төрийн аудитын байгууллагад тавьж байгаа шаардлагад энэ аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, аудитын эцсийн үр дүнд нөлөөлөх субъектив нөлөөллийг бууруулахад чиглэсэн цахим шилжилтийг бид хийж хэрэгжүүлэхээр эхлээд байгаа болно.

Бид төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны дахин инженерчлэлийн ажлыг хийхэд цахим шилжилтийн хөтөлбөрийн хүрээнд чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоогоо бэхжүүлж, 2025 онд бид аудитын үйл ажиллагааны үр нөлөө, эцсийн дүндээ иргэдийн амьдралд сайжруулахад чиглэсэн тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж ажиллаж байна.

Анхаарал хандуулсан эрхэм гишүүд Та бүхэнд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн мэдээллийг сонсьё.

Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэвээндоржийн Эрдэнэбат. 2 дугаар микрофон.

Ц.Эрдэнэбат: Төрийн байгуулалтын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Эдийн засаг, хөгжлийн яамнаас танилцуулга тавья.

Танилцуулгыг би 3 хэсгээс танилцуулъя. Дэлгэц дээр презентац гарах юм.

Нэгдүгээрт, төрийн бодлогод яг энэ процессын дахин инженерчлэл болон хүн цөмтэй үйлчилгээний талаар орсон байдал.

Хоёрдугаарт, өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярья.

Хугацаа бага өгсөн учраас би зарим нэг Та бүхний мэдэх мэдээллийг алгасаад явчихъя.

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд эдгээр заалтууд орсон. Тэр тусмаа ялангуяа улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэл болгож төрийн үйлчилгээ, мөн процессын дахин инженерчлэл, бүтээмж, зөвшөөрөл, төв 2.0 гэх мэтчилэнгийн заалтууд орсон. Өөрөөр хэлбэл Монгол Улс 2026 онд энэ чиглэлээр тэргүүлэх чиглэл, бодлого болгож ажиллахаар Улсын Их Хурал маргааш, нөгөөдөр чуулганаараа батлагдвал чиглэл маань гараад явж байгаа юм. Бодлого маань.

Мөн энэ дээр Та бүхний мэдэж байгаачлан 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд онцлох заалтууд, төрийн албаны реформ, төсвийн зардлын реформ гэх мэтчилний заалтуудыг бүр тодорхой тоогоор оруулаад явж байна.

Төрийн процессын дахин инженерчлэлийг бид юу гэж харж байна гэхээр төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, төрөөс бизнесийнхэнд үзүүлж байгаа үйлчилгээ, гурав дахь нь зөвшөөрөл буюу [license.mn](https://www.license.mn) гээд эхнийх нь буюу төрийн иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ маань e-mongol-лоор дамжаад явж байгаа.

Энэ дээр та бүхний мэдэж байгаачлан нийтдээ 1.7 сая иргэн давхардсан тоогоор 41 хандалт аваад явж байна.

Мөн e-business-ийн үйлчилгээ ч сайжирсны үр дүнд олон улс дахь манай цахим засаглалын индекс урагшилж байгаа.

Гэсэн хэдий ч бизнес орчны индексүүдийг гаргадаг дэлхийн банк болон дотоодын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, өөр байгууллагуудын судалгаагаар бид цаашид нэлээд энэ индексүүдийг сайжруулах буюу үзүүлэлтүүдийг сайжруулах орон зай байна. Энэ дээр огцом дорвитой алхмууд хийх шаардлагатай байна гэдгийг харуулж байна. Тухайлбал, эдгээр индексүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд бизнесийн орчинд бизнес эхлүүлэх, барилгын зөвшөөрөл, эсвэл эрчим хүчний холболт гэх мэтчилэн тодорхой зарим ажлууд дээр үе шат болон зарцуулж байгаа хоног хугацаа урт гэж гарч ирж байна.

Үүнтэй холбоотойгоор Эдийн засаг, хөгжлийн яаман дээр зөвшөөрлийн нэгдсэн сан бүрдүүлэх ажил хийгдээд явж байна.

Тэгээд энэ ажлууд хийгдээд, туршилтын болон зарим ажлууд хийгдсэнээр тодорхой үр дүн, ахиц гарч байгаа.

Тэгээд үүнтэй холбоотойгоор одоо license.mn дээр одоогийн байдлаар төрийн 44 байгууллагын зөвшөөрлийн ажлууд нь бүртгэгдээд явж байгаа.

Онцлон дурдвал Гаалийн ерөнхий газар болон Сангийн яам энэ системд эрт нэвтэрсний үр дүнд олон ажлууд тодорхой байгууллагууд дээр нэлээн ахицтай ажиллаад явж байна. Зарим холбогдох байгууллагууд энэ дээр бид 2026, 2027, 2028 он дээр илүү түлхэцтэй ажиллах шаардлагатай байгаа юм.

Мөн үүнтэй холбоотойгоор Дэлхийн банкнаас “Ухаалаг засаг-2” гэсэн төсөл хэрэгжиж байгаа. Төслийн үр шим хүртэгчээр Эдийн засаг, хөгжлийн яам ажиллаж байгаа. Энэ хүрээнд энэ процессын дахин инженерчлэл болон зөвшөөрлийн цахим системийн ажил, хөгжүүлэлт хийгдээд явж байгаа. Энэ ажил маань 2027 он хүртэл үргэлжилнэ.

2025 оны байдлаар хийгдсэн зарим ажлууд болон Эдийн засаг, хөгжлийн яам дээр хийгдсэн ажлуудыг танилцуулъя. Тухайлбал, энэ төслийн хүрээнд болон процессын дахин инженерчлэлийн хүрээнд тодорхой байгууллагууд дээр шинжилгээ хийгдсэн байдаг байгаа.

Яг эхний үе шат дээрээ нийслэл болон дүүргүүдийн хэмжээнд хийгдсэн. Энэ хүрээнд авч байгаа зөвшөөрлүүдийн тоо, тэр нь e-business, license.mn дээр яаж орж байгаа, үүний процессын дахин инженерчлэлийн талаар ажлууд хийгдээд явж байна.

Энэ хүрээнд суурь шинжилгээ хийсэн. Мөн 24 багц тайлан гаргасан. 398 процессын зураглал хийгдсэн байгаа. Тэгээд энэ хийгдсэн материалууд миний презентацийн ар талд QR кодоор байгаа учраас нэлээд их файлууд учраас хэвлэж авчирч амжсангүй. Эрхэм гишүүн Та бүхэн зургийг нь аваад авч үзэхэд нээлттэй байх юм.

Ер нь цаашдаа энэ ажлыг хийх ёстой юу гэдэг дээр дүн шинжилгээ хийж үзэхэд нэр бүхий 12 байгууллага дээр 8-аас доош бол шаардлаггүй, 8-аас дээш шаардлагатай гэж авч үздэг. Аргачлалын дагуу. Ихэнх нь 16, 10-аас дээш буюу 20-оос дээш буюу зайлшгүй процессын дахин инженерчлэл хийгдэх шаардлагатай гэж гарсан учраас цааш нь энэ ажлууд нь хийгдэх ёстой гэж үзэж ажлууд хийгдээд явж байна.

Мөн яг энэ хүрээндээ хийсэн зарим ажлуудыг энэ дээр Та бүхэнд үзүүлж байна. Энэ нарийн мэдээллүүд нь QR кодоор хүргэгдэх учраас Та бүхэн эндээс харах байх.

Бид цаашдаа энэ асуудлыгаа ингэж 4 хүрээнд ангилж харж байгаа. Энэ ажлууд маань дараа нь асуулт хариултын үед дэлгэрүүлээд ярьж болох байх гээд.

Хамгийн чухал нь төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ буюу e-mongolia төрөөс, бизнесийнхэнд үзүүлж байгаа үйлчилгээ буюу e-business, дээрээс нь license.mn 2.0 гээд. Энэ дээр энэ процессынхоо хувьд цаашаа явах зураглал маань гарсан. Энэ дагуу холбогдох хүмүүс, бизнес эрхлэгчид болон хувийн хэвшил, бодлого боловсруулагчдад нэлээд үр дүнтэй гарах юм.

Үүний үндсэн суурь зарчим нь Government-as-a-Platform буюу сэтгэлгээ, хандлагын томоохон өөрчлөлт хийх чиглэлээр загварчлалыг нь боловсруулаад ажиллаж байна.

Энэ дээр тухайлан жишээ авч үзвэл процессын дахин инженерчлэл нь хүүхэд харах үйлчилгээ дээр олон процесс дамжлага дамжаад 10 байсан бол дахин инженерчлэл гэж загвар гарсны дараа энэ ингэж 5-д буюу тодорхой хугацаа, цаг, чанарын үзүүлэлт сайжрахар гарч ирж байгаа юм. Энэ байдлаар энэ олон жишээнүүд хийгдсэн байгаа. Тэр тайлангууд дээр байгаа учраас.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд цахим хэлбэрт шилжүүлэлтийгээ чанаржуулан явах, одоогийн байдлаар зарим төрийн байгууллага болон төрийн албан хаагчдын дунд цахимыг зөвхөн PDF буюу эсвэл зурган форматад орохыг цахимжих гэж ойлгоод байгаа бол үүнийг бүр цааш нь чанартай тоон өгөгдөл рүү аваачих гэх мэтчилэн бид тодорхой ажлуудыг төлөвлөөд, тооцоолоод явж байгаа юм.

Тэгээд цаг бага байгаа учраас би үүнийгээ алгасъя. Нэлээд ажлууд нь бас 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр хийгдсэн байгаа. Энэ презентацийг Та бүхэнд танилцуулах учраас би танилцуулгаа товчлоод дуусгая.

Уучлаарай. Энэ QR кодтой хэсэг дээр саяын ярьсан олон тэр баримт бичгүүд, тайлангууд бүгд байгаа тул Та бүхэн энэ дээрээс нарийвчилсан мэдээллийг авч үзнэ үү. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Монголбанкны мэдээллийг Монголбанкны Мэдээллийн технологийн газрын дарга Бямба-Очирын Хосбаяр. 8 номерын микрофон.

Б.Хосбаяр: Монголбанканд процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлж буй ажлын тайланг эрхэм гишүүд мэдээлэл товч хүргэе.

Монголбанкны үйл ажиллагааг Засгийн газрын баримталж буй цахим засаглал концепцуудтай нийцүүлэх замаар хүн төвтэй, үр ашигтай, илүү ухаалаг төрийн үйлчилгээг бий болгох зорилгоор процессын дахин инженерчлэл, арга зүйг нэвтрүүлэх саналыг боловсруулах ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан байгаа.

Ажлын хэсгийн зүгээс процессын дахин инженерчлэлийг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор дараах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Үүнд:

► Нэгдүгээр үе шат нь, **одоогийн нөхцөл байдлыг шинэчлэх.**

Одоогийн процессуудыг бүрэн ойлгох, үйл ажиллагааны зардлыг тодорхойлох, зураглал гаргах асуудлыг тодорхойлох, үргүй зардлыг тодорхойлох гэсэн нэгдүгээр үе шат байна.

► Хоёрдугаар үе шат нь, **хэрэгцээ, зорилгыг тодорхойлох.**

Шинэчлэлийн чиглэлийг тогтоох зорилго, шалгуур үзүүлэлт KPI-г тодорхойлох, стратегитай уялдуулах гэсэн хоёрдугаар үе шаттай.

► Гуравдугаар үе шат нь, **шинэ процессын загварыг гаргах.**

Үлүү үр ашигтай шийдэл боловсруулах “То Ве” загварыг гаргах, автоматжуулалт ба системийн шинэчлэлтийг хийх үе шаттай байна.

► Дөрөвдүгээр үе шат нь, **шийдвэр гаргах, баталгаажуулах.**

Шинэ загварыг албан ёсны болгох, удирдлагад танилцуулах, эрсдэл, зардлыг болон холбогдох хугацааг тодорхойлох гэсэн үе шаттай байна.

► Тав дахь үе шат нь, **түүнийг хэрэгжүүлэх.**

Шинэ процессуудыг бодитойгоор нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, систем хөгжүүлэх гэсэн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Өнөөдрийг хүртэл хийж гүйцэтгэсэн ажлын тухай гэх юм бол процессын дахин инженерчлэлийн хийх аргачлалуудын амжилттай хэрэгжүүлэх арга замын талаар олон улсын менежментийн системийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай уулзаж зохион байгуулсан бөгөөд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс зөвлөх үйлчилгээний талаар авахаар судалж байна.

Процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэх төслийн шаардлагыг тодорхойлсон төслийг амжилттай хэрэгжүүлэх арга барилыг тодорхойлсон бөгөөд төслийн зорилгыг мөн тодорхойлсон байна.

2025 оны 05 сарын 21-нд удирдах албан тушаалтнуудын дунд хэлэлцүүлэг хийсэн бөгөөд одоогийн байдлаар нөхцөл байдлын шинжилгээг хэрхэн хийх талаар бусад төрийн байгууллага дээр хийгдсэн PDI /People, Data, Infrastructure/ кэйсүүдийн туршлагыг судалсан үйл явцтай явж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн мэдээлэл.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Чадраабалын Өнөрбаяр. 4 номерын микрофон.

Ч.Өнөрбаяр: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 2022 онд батлагдсан Засгийн газрын хяналтын тухай хуульд заасны дагуу байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргаж боловсруулдаг.

Тэгээд энэ хүрээнд өмнө нь бас Д.Амарбаясгалан даргыг сайд байх үед 2 удаа процессын инженерчлэл хийсэн. Манай газраас.

Нэг нь, 2023 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаман дээр, 2024 онд Эрүүл мэндийн яаман дээр.

Ингээд 2 удаа процессын дахин инженерчлэл хийгээд, тайлангаа Засгийн газрын хуралдаанаар танилцуулаад шийдвэр гаргаад явж байсан юм билээ.

Хамтарсан Засгийн газар гарснаас хойш Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр, мөн түүний харьяа Ойн газар дээр процессын дахин инженерчлэл хийж дуусаад, тайлан бичигдэж дуусаад одоо Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэл ажил хангаад явж байгаа.

Энэ хүрээнд бид ерөнхийдөө 6 чиглэлийн аргачлалыг боловсруулж ажиллаж байгаа. Энд тухайлбал хуулийн шинжилгээ буюу зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ.

Энэ нь Та бүхэн мэдэж байгаа. Бүртгэлгүй баахан дүрэм журам гаргадаг. Яамд дээр. Тэгээд тэр нь Хууль зүйн яамд зарим нь бүртгэлтэй бүртгэлгүй, зарим нь хуулиар эрх олгогдоогүй, эрх шилжээгүй байхад дүрэм, журам

тогтоодог зүйл байгаа. Энэ бүгд дээр дүн шинжилгээ хийгээд ямар ямар дүрэм, журмууд нь хаанаа зөрчилтэй юм бэ, хуульд нийцсэн юм уу, нийцээгүй юм уу гэдэг асуудлуудыг нь гаргаж ирсэн.

Хоёрдугаарт, стратеги бодлого, төлөвлөлт, чиг үүргийн шинжилгээ.

Энэ дээр хэлэхэд Монгол Улс урт хугацааны маш олон бодлогын баримт бичиг баталдаг. Дунд хугацааны. Тэгээд энэ бодлогын баримт бичгүүд нь өөрөө салбарынхаа яамны стратеги бодлоготой бас уялддаггүй.

Мөн уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр маш олон улсын гэрээ конвенцод нэгдэж орсон хэрнээ тэр нь үндэсний хууль тогтоомж, тухайн салбарт мөрдөгдөж байгаа хууль, дүрэмтэй уялддаггүй байдлуудыг энэ процессын дахин инженерчлэл гаргаж ирсэн.

Гуравт нь, Монгол Улсад энэ эрсдэлийн удирдлагын тогтолцоог ер нь төрийн байгууллагуудад хангалттай нэвтрүүлж чадаагүй явж ирсэн. Тэгээд бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр хийж байгаа процессын дахин инженерчлэлээр энэ эрсдэлийн удирдлагын түвшинг үнэлдэг байя гэдэг арга аргачлалыг оруулж ирсэн.

Дөрөвт нь, нэг яригддаг зүйлс яамд дээр байгаа зөвшөөрлийн систем. Энэ дээр бид процессыг нь зураглал хийж үзсэн. Одоогоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт дээр 39 төрлийн зөвшөөрөл байсан. Тэгээд энэ дээр бид нар бас процессыг нь зураглал хийгээд тайландаа тусгаад явж байгаа.

Хамгийн сүүлд нь системийн шинжилгээ болоод төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааг мөн энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс дээр хийсэн. Нийтдээ тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт төрийн албан хаагч нар болоод энэ салбарт үйлчилгээ авч байгаа, төрийн үйлчилгээ авч байгаа 1150 аж ахуйн нэгж, иргэдийг бид судалгаандаа хамруулсан.

Мөн зардал, үр ашгийн шинжилгээ энэ тэрийг хийгээд ингээд судалгааны аргачлалаа боловсруулсан байж байгаа.

Ер нь судалгааны ажлын хүрээнд:

- бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах шаардлагатай,
- салбар эрх зүйн хууль тогтоомжийг шинэчлэх шаардлагатай,
- яамны оновчтой бүтэц, зохион байгуулалтыг хийх шаардлагатай,
- чиг үүргүүдийн давхардлыг нь арилгах шаардлагатай,
- зөвшөөрлийн процессыг цахимжуулах шаардлагатай

гээд ялангуяа иргэн, аж ахуйн нэгжид учирч буй хүндрэлийг бууруулах, хүний нөөцийн стратеги, эрсдэлийн удирдлагын нэвтрүүлэх чиглэлээр нийт 68 дүгнэлт, 54 санал, зөвлөмжийг боловсруулсан байж байгаа.

Одоогоор Хяналт хэрэгжүүлэх газраас яг ямар ажил хийгдээд явж байна гэхээр өнгөрсөн жил Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүсэлт гаргасан юм билээ. Манай газарт. Процессын дахин инженерчлэл хийж өгөөч гээд.

Энэ хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтарсан тушаал гаргаад ажлын хэсэг байгуулаад процессын дахин инженерлэлийн ажлыг эхлүүлээд явж байгаа.

Энэ ажил ерөнхийдөө олон улсын 4 жишиг үзүүлэлтийг тооцоод 8 аргачлалын дагуу хийхээр төлөвлөж байна.

Энд мэдээж хэрэг хууль сахиулах байгууллагын чиг үүрэг, цагдаагийн байгууллагын хариуцлага, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэсэн үзүүлэлтүүд нь юу болж байгаа юм.

Цагдаагийн үйлчилгээ, цагдаагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний түвшин ямар байгаа юм гэх мэтчилэнгээр ерөнхийдөө 4 гээд олон улсын тогтсон аргачлалыг ашиглаад процессын дахин инженерчлэлийн ажил яг ид хийгдээд явж байгаа.

Манайх хуулиараа хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэг рүү орж болдоггүй. Гэхдээ яг тухайн байгууллагуудын, ялангуяа Засгийн газрын харьяа байгууллагуудын захиргааны чиг үүрэгтэй холбоотой юман дээр бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэл хийх чиглэлээр тодорхой санал, дүгнэлт гаргах чиг үүрэг байдаг. Энэ хүрээндээ цагдаагийн байгууллага дээр процессын шинэчлэл хийгдэж байгаа гэж ойлгож болно.

Өмнө нь яамд дээр хийсэн болоод Байгаль орчны яам дээр хийсэн арга аргачлалаа бид сайжруулаад цагдаа дээр хийж байгаа ажил дээр ашиглаж байгаа.

Хамгийн сүүлд нь хэлэхэд Монгол Улсад процессын дахин инженерчлэлтэй холбоотой нийтлэг гарын авлага байх хэрэгтэй гэдэг санал санаачилга гарч ирсэн юм билээ. Тэгээд Засгийн газрын 2024 оны 22 дугаар тогтоолоор процессын дахин инженерчлэлтэй холбоотой нийтлэг арга, аргачлалыг боловсруулах ёстой гэдэг үүрэг чиглэлийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт өгсөн байдаг.

Энэ дагуу бид 2024 оны 12 дугаар сард төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагууд, нийт 41 байгууллагын 100 гаруй төлөөллийг оролцуулаад төрийн

байгууллагууд процессын дахин инженерчлэлийг хийх нийтлэг аргачлал зааврыг боловсруулаад явж байгаа.

Тэгээд энэ удахгүй бэлэн болоод, үүнийг Засгийн газрын хуралдаанд танилцуулаад Улсын Их Хурлын ажлын хэсэг, холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ гэсэн бодолтой байж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн мэдээллийг албаны дарга Сүхээгийн Тэнгис хийнэ. 1 номер.

С.Тэнгис: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөл нь сая 02 сарын 19-нд хувийн хэвшилтэй хамтарсан буюу хувийн хэвшлийн тэргүүн компаниудын олонхын оролцоотойгоор зөвлөл бүрэлдэхүүнээ өөрчилсөн.

Тэгээд энэ өөрчилсөн шалтгаануудын нэг нь төрийн бүтээмж дээшлүүлэх, хэмнэлт хийх зорилгоор хувийн хэвшилд ашиглагдаж байгаа тэр сайн туршлагуудыг төрд нэвтрүүлэх, хамтран ажиллах зорилгоор бүтэц бүрэлдэхүүнээ л өөрчилсөн.

Үүнээс хойш яг энэ процессын дахин инженерчлэлийн чиглэлээр манайх зөвлөл учраас яг дагнаж аль нэг байгууллагыг дахин инженерчлэлийг хийгээгүй. Гэхдээ дахин инженерчлэлийн чиглэлээр ажиллаж байгаа байгууллагууд, энэ дурдагдсан байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа явцтай танилцаж, мөн санал хүсэлтийг зөвлөлийн хурлаараа хэлэлцэж тодорхой шийдвэрүүдийг гаргасан байж байгаа.

Зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн, мөн танилцсан зүйлсүүдийн хамгийн их ажиглагдсан зүйлээс нь энд ярих нь зөв байх гэж бодож байна. Үүнд, нэгдүгээрт байгууллагууд процессын дахин инженерчлэл гэдгийг бүрэн сайн ойлгосон байгууллага их ховор байна. Бараг байхгүйтэй адилхан байна.

Өөрөөр хэлбэл процессын дахин инженерчлэл гэдгийг чинь нөгөө Америк MIT /Massachusetts Institute of Technology/-ийнхэн тодорхойлохдоо тухайн процесс, үйл ажиллагаа, арга замыг өмнө нь байгаагүй радикал хэлбэрээр хийхийг ойлгож байгаа байхгүй юу. Тэгж байж дахин инженерчлэл гэдэг нэрийг зүүх эрхийг олж авч байгаа.

Гэтэл байгууллагууд зөвхөн тодорхой нэг үйл ажиллагаандаа өөрчлөлт ч юм уу, эсвэл дүрэм, журмаа өөрчлөөд ч юм уу дахин инженерчлэлт хийж байна гэж маш их ярьж байгаа.

Тэгэхээр дахин инженерчлэл гэдгийг нэгдүгээрт нэр томьёо, агуулга, зарчмын хувьд яг зөвөөр тодорхойлж өгөхгүй бол ямар үр дагаварт хүрэх гэж

байна гэхээр бас нэг ийм дахин инженерчлэл гэдэг нэр томьёог ашигласан баахан нэг үйл ажиллагаа яваад өнгөрөх вий гэдэг тийм зүйл болж байгаа.

Өмнө нь яах вэ олон салбар, нэр томьёонд ийм асуудлууд үүсэж байсан. Тэгээд Их Хурал дээр мэргэжлийн хүмүүс байгаа ажлын хэсэг учраас Их Хурлаас гарахад тэр тогтоол шийдвэр бас их чухал байгаа.

Хоёрдугаарт, Хэмнэл, бүтээмжийн зөвлөл дээр хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын бүтээмж, дахин инженерчлэлийн хийж байгаа арга хэмжээнүүдийг харьцуулж үзсэн.

Үүн дээр Та бүхний мэдэж байгаа нэг том зарчмын ялгаа гарч байгаа. Хувийн хэвшлийн байгууллага, бизнесийн байгууллага хуульд хориглоогүй үйл ажиллагааг өөрийнхөө гүйцэтгэх захирлынхаа ТУЗ-ийнхөө эрх хэмжээгээр дуртай янзаараа процессоо өөрчилж үр дүнд хүрч чадаж байгаа юм.

Нөгөө талаас төрийн байгууллагууд, ялангуяа төрийн захиргааны байгууллагууд зөвхөн хуульд заасан чиг үүргийн хүрээнд тухайлсан хуулиар өгөгдсөн тэр чиг үүрэг, процесс дарааллын дагуу ажилладаг учраас процессын дахин инженерчлэлийг хийх гэхэд маш их том захиргааны хэм хэмжээний актын түвшний тийм бэрхшээл учирч байгаа.

Тэгэхээр эндээс юу гэж хэлэх гээд байна гэхээр энд Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа нь их учиртай. Тийм ээ. Яг тэр байгууллагуудад, тэр салбарт процессыг нь дахин инженерчлэлийг хийх тэр эрх зүйн үндэс, орон зайг нь тэлж өгөхгүй бол төрийн байгууллагууд зөвхөн өөрийнхөө байгууллагынхаа дотоод дүрэм журмын хэмжээнд юм шийдвэрлэе гэхээр үнэхээр захиргааны тэр боломж нь бүрдэхгүй байгаа юм.

Тэгэхээр одоо жишээ нь дахин инженерчлэлийг байгууллагаар нь биш бид нар уг нь аль болох тийм салбар юм уу, төрийн аль нэг чиг үүргээр нь авч үзэх ёстой юм билээ.

Эрүүл мэндийн салбараар жишээ авах юм бол нэгдүгээр эмнэлгийн үйл ажиллагаанд хийх гэхээр зөвхөн бид процессын дахин инженерчлэлийн хэдхэн үзүүлэлтийг л харж чадна.

Гэтэл бид Төрийн хэмнэлтийн зөвлөл дээр бас ярилцаж байгаад ер нь процессын дахин инженерчлэлийг хийх юм бол зөвхөн хэмнэлтээс гадна чанар, сэтгэл ханамж, үйлчилгээний хурд, зардал, орлогын өгөөж гэх мэт олон үзүүлэлтээс бүрдсэн 31 KPI_[Key Performance Indicator буюу Гүйцэтгэлийн гол үзүүлэлт] үзүүлэлтийг тодорхойлсон байхгүй юу.

Процессын дахин инженерчлэл хийгээд 31 янзын KPI үзүүлэлтийг нь сайжруулж болж байна. Үүнийгээ хэмжчхээд энэ үзүүлэлтүүдээ өөрчилснөөр нь

тэр дахин инженерчлэл хийсэн үр дагаврыг нь үнэлээд яг зөв хийжээ, буруу хийжээ, сайн хийжээ, муу хийжээ гэдгийг нь ингэж үнэлье гэж үзэж байгаа.

Гэтэл тэр 31 KPI чинь эрүүл мэндийн салбараар жишээ авах юм бол Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн хөгжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, тэр сайдын тушаалаар, Засгийн газрын тогтоолоор, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулиар гээд тэр тусламж, үйлчилгээ маань өөрөө босоо тогтолцоонд ингэж нөгөө дээрээсээ доошоо хуулиар зохицуулсан байхад түүнд дахин инженерчлэл хийж, үе шат болгон дээр нь орон зайг нь гаргаж өгөхгүй болохоор яаж байна вэ гэхээр нөгөө дахин инженерлэлтийг яаж ч хүсээд тэр байгууллага ойлгоод, эргээгээд нөгөө дүрэм журмын саад нь тулгарах тийм л асуудал үүсэж байгаа юм.

Нөгөө талаас өнгөрсөн 2024 оны 06 сарын 07-нд Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагуулж 109 хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон.

109-ийн нэмэлт, өөрчлөлтөөр бид тодорхой салбарыг зорьж дахин инженерчлэлийн боломжийг бүрдүүлсэн. Үүний нэг нь улсын бүртгэлийн салбарт. Түрүүн бас байгууллагуудын танилцуулга гарч байгаа. E-Business гээд төрөөс 3 том платформыг л цахим хэлбэрээр нийтэд үзүүлж байгаа.

- ▷ Нэгдүгээрт, **e-Mongolia**;
- ▷ Хоёрдугаарт, **e-Business**;
- ▷ Гуравдугаарт, **e-Cabinet** буюу дотооддоо.

Тэгэхээр бидний хамгийн боломжтой нь хуулиар 2024 онд үндсийг нь тавьсан e-Business платформ дээр бид яг одоо Улсын бүртгэлийн байгууллага Цахим хөгжлийн яамтай хамтраад дахин инженерчилсэн процесс бүхий хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Бас тодорхой хэмжээний ахицууд гарсан.

Бид энд дахин инженерчлэл хийсэн гэж үр дүн гаргахын тулд хиймэл оюун ухаанаар тодорхой чиг үүргийг нь гүйцэтгэх боломжийг гаргахаар ер нь боломжтой гэдэг дүгнэлт гарчхад байгаа юм. Өөрөөр хэлбэл улсын бүртгэгчийн хийгээд байгаа тэр зарим ажлыг бид хиймэл оюун ухаанаар хийх боломж бүрдчихэж байгаа юм.

Тэгэхээр Улсын бүртгэгч “хэлбэрийн шаардлага” биш, илүү “агуулгын шаардлага” дээр анхаараад явж болно.

Мөн худалдан авах ажиллагаа байгаа. Төрийн худалдан авах ажиллагаа. Тийм ээ. Тодорхой төрийн өмчит компаниуд дээр хэрэгжиж байгаа.

Тендерт ирүүлсэн материалын хэлбэрийн шаардлагыг хиймэл оюун ухаанаар шалгаад нөгөө тендерийн хорооны чинь хийж байгаа ажлын механик хэсэг нь бүгдийг хиймэл оюунаар хийчхэж байгаа юм.

Тэгэхээр яах вэ. Зөвхөн чанарын үнэлгээг л тендерийн хорооны гишүүд хийх боломжтой болж байгаа юм.

Дараа нь сая миний дурдсан e-Cabinet гээд Засгийн газрын хуралдааны систем.

Засгийн газрын хуралдааны систем дээр процессыг нь дахин инженерчлэл хийх талаар судалгаа хийж үзээд, тухайлах юм бол зөвхөн цаасных нь хэрэглээг 98.6 хувиар бууруулж болох, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг гаргах хурдыг 10 дахин бууруулж болохоор тооцоог нь гаргасан байгаа.

Үүнийгээ мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргээд Засгийн газрын хуралдаанд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Ийм мэдээлэл хүргэх байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ингээд Үндэсний статистикийн газар, Үндэсний Аудитын газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк, тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн мэдээллийг сонслоо.

Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан.

2024 оны 10 сарын 04-ний өдрийн 173 дугаар захирамжаар төрийн үйлчилгээг хүн төвтэй болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процессын дахин инженерчлэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай гээд Ч.Анар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулсан.

Ингээд Ч.Анар гишүүний ажлын хэсгийн тайлан, мэдээллийг сонсьё. Ч.Анар гишүүний микрофоныг нээе.

Ч.Анар: Эрхэм Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг эрье.

Процессын дахин инженерчлэлийн талаар ерөнхийд нь маш товчхон дүгнэлт хийх танилцуулга хийе.

Тэгэхээр анх энэ ойлголт 1990 онд дэлхий дээр хэрэгжиж эхлээд Монгол Улсын Их Хурал 1996 онд процессын дахин инженерчлэл хийнэ гэдэг тогтоол баталсан байдаг юм байна.

Ажил хэрэг болсон нь 2022 оноос Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яаман дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хийгдэж эхэлсэн.

Түрүүний бүх дурдаж байгаачлан бодлогын баримт бичгүүд дээр маш их суусан байгаа.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын баримт бичиг, 2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2024-2028, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө, ялангуяа одоо бид нарын хэлэлцэж байгаа 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний хөтөлбөрт нийт хийгдэх ажлын дөрөвний нэг нь процессын дахин инженерчлэл болон түүнтэй хамааралтай ажлууд байгаа.

Тэгэхээр манай ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд Та бүхэнд тараагдсан материал дээр байгаа. Түүн дээр олон судалгаа хийж үзсэн. Та бүхэн ч гэсэн сая холбогдох газруудын мэдээллийг сонслоо.

Тэгэхээр ажлын хэсэг ямар дүгнэлтэд хүрээд байгаа вэ гэхээр процессын дахин инженерчлэл гэдэг ойлголтоо ойлгоогүй маш их олон ажлууд хийгдэж байна.

Засгийн газар болон Их Хурлын харьяа, ер нь төрийн бүтцийн хэмжээнд. Үүний үндсэн шалтгаан нь өөрөө үзэл баримтлал нь юу юм, нэгдсэн үзэл баримтлалтай болох, хүн төвтэй байх гэдэг ойлголт байхгүй буюу төр иргэндээ хүрч үйлчлэх гэдэг ойлголт байхгүй.

Энэ нь өөрөө өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, технологийн хөгжлөөс шалтгаалаад бид өнөөдөр иргэндээ зардал чирэгдэл, хүнд сурталгүй хүрч үйлчлэх бүрэн бололцоотой болсон байгаа. Тэр нь хэрэгжихгүй байгаа юм.

Хэрэгжихгүй болсон байгаа үндсэн шалтгаан нь процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэгч Засгийн газрын болон Их Хурлын харьяа байгууллагууд маш олон ялгаатай ойлголттой. Та бүхэн сонсож байна.

Цахимжилт, автоматжуулалт гэсэн ойлголт маш өргөн хүрээнд явж байгаа.

Сая Засгийн газрын Хэрэг эрхлэхээс танилцуулж байгаагийн хүрээнд хууль, эрх зүйн орчин бас бүрдээгүй байгаа. Үүнээс үүдээд хамгийн төвөгтэй асуудал нь юу вэ гэхээр нэгдсэн үзэл баримтлал, ойлголтгүйгээс үүдээд маш их давхардсан худалдан авалтууд явагдаж эхэлж байна. Ялангуяа Засгийн газар үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө бид дэлхийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хүлээлтийг дагаад хийхээс өөр аргагүй. Хийхгүй бол бид хоцрогдоно.

Тэгэхээр үүнийг хийхтэй холбогдуулаад нэгдсэн ойлголт, үзэл баримтлал байхгүйн улмаас маш их үргүй худалдан авалт, тендер явж байна. Нөгөө талаасаа төрийн хэрэгжүүлэгч байгууллагуудын хамгийн том хүндрэл бэрхшээл нэгдсэн ойлголт, үзэл баримтлалаас гадна хууль эрх зүйн орчин.

Тэгэхээр процессын дахин инженерчлэл гэдэг бол мэдээж хүний амьдрал дээр хэрэгжихдээ технологиор дамжиж хэрэгжиж байгаа боловч хамгийн гол ойлголт нь төрийн засаглалын бүтэц, хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ бол Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ер нь онцгойлон анхаарах шаардлагатай зүйл байгаа.

Үр дүнд нь юу хэлэх юм бэ гэхээр:

- ▶ Төрийн үйл ажиллагааны зардал 30-аас 50 хувь буурна.
- ▶ Процессын цикл 40-өөс 65 хувь буурна.
- ▶ Бүтээмж 20-оос 40 хувиар нэмэгддэг.

Залуучуудын төрд итгэх итгэл нэмэгдэнэ.

Өнөөдөр яг нэгдсэн ойлголт байхгүйн улмаас энэ гоё нэрээр, ер нь нийтлэг ажиглагдаж байгаа зүйл

- ▶ хиймэл оюун ухаан,
- ▶ big data,
- ▶ процессын дахин инженерчлэл

гэсэн нэрээр үнэлж, дүгнэж чадахгүйн улмаас маш их улсын төсөв зарцуулагдахаар хандлагатай байгаа юм.

Тэгэхээр үүнийг шийдвэрлэхгүй бол бид өнөөдөр “процессын дахин инженерчлэл” гэдэг нэрээр төрийн бүтцээ улам данхайлгаад байгаа байхгүй юу. Одоо “бүтээмжийн менежер”, “хяналтын менежер”.

Ажлын хэсэг ерөнхийдөө холбогдох төрийн байгууллагуудтай уулзсан.

Хуульдаа заасан болон чиг үүргийнхээ дагуу давхардсан чиг үүрэгтэй маш олон байгууллагууд байгаа.

Өнөөдөр Та бүхэн сонсож байна. Тийм ээ.

- E-Governance Academy,
- E-Mongolia Academy,

- ▶ Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар,
 - ▶ Төрийн хэмнэлт, бүтээмжийн Үндэсний зөвлөл,
 - ▶ Төрийн бүтээмжийн Үндэсний хороо,
 - ▶ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар,
 - ▶ Салбар дундын уялдааг гаргах Үндэсний хороо,
- засаглалыг хэрэгжүүлэх Эдийн засаг, хөгжлийн яам гэх мэтчилэн.

Зөвхөн Засгийн газрын харьяаны байгууллагад.

Эдгээрээс хэн нь яг үндсэндээ энэ процессын дахин инженерчлэлийг хийх юм бэ гэдэг ойлголт байхгүй.

Тэгэхээр үүнийг Их Хурлын зүгээс нэгдсэн чиглэл, тогтоол Төрийн байгуулалтын байнгын хороо гаргаж аргачлал, удирдамжаар хангахгүй бол эдгээр байгууллагууд уялдахгүй байна.

Хоёрдугаарт, үнэхээр үйл ажиллагаа явуулаад хийж байгаа байгууллагуудын буруу байхгүй. Түрүүн тэр С.Тэнгис даргын ярьж байгаачлан тухайн чиг үүргийн байгууллагууд харьяа хууль, эрх зүйн акт, эрх хэмжээний хүрээнд л процессоо сайжруулаад байгаа юм. Энэ нь өөрөө “цахимжилт” болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ “цахимжилт” гэдэг маань “процессын дахин инженерчлэл” биш байгаа юм.

Процессын дахин инженерчлэл гэдэг маань бүх юм маань 0-ээс эхлэхийг хэлж байгаа юм.

Тэгэхээр үүнийг зайлшгүй хийх нь нэн шаардлагатай байна.

Тэгэхээр нэн түрүүнд хийх шаардлагатай зүйл бол хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх, түүний дараагаар арга зүй, үзэл баримтлалыг баталж өгөх, хүн төвтэй гэдэг ойлголтоо батлах зайлшгүй шаардлагатай байна гэж ажлын хэсэг дүгнэсэн байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Саяын танилцуулгуудтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Ч.Анар гишүүнээр тасаллаа. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Энэ процессын дахин инженерчлэлтэй холбогдолтойгоор Үндэсний аудитын газраас нэг асуулт байгаа юм.

2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн хөтөлбөр дээр “төрийн байгууллагуудын аудитын цахим системийг гаднын тусламжаар хийнэ” гэж орсон байна лээ.

Тэгэхээр Үндэсний аудитын газар, төрийн байгууллагуудын бүх мэдээлэл буюу улсын нууцтай холбоотой эмзэг мэдээллүүдийг хадгалдаг газар. Гаднын тусламжаар гэдэг маань өөрөө гаднын хөнгөлөлттэй зээл, санхүүжилт юм уу, эсвэл гадна талаас үнэгүй өгч байгаа систем юм уу?

Үүнийг яагаад асууж байгаа юм бэ гэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр асуугаад Үндэсний аудитаас хүн байгаагүй. Энэ нь өөрөө аюулгүй байдал болоод, яг эргээгээд бид процессынхоо дахин инженерчлэлтэй ямар системтэй холбогдох гэж байгаа гэдгээ мэдэх шаардлагатай гэж үүднээс тодруулга хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Аудитын газар 9 номер. Өөрийгөө танилцуулаарай.

З.Цэдэнжав: Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав. Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Бид төсвийн ерөнхийлөн захирагчийн хувиар Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд саналаа өгөхдөө 3 санал өгсөн.

Манай саналуудаас төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийг шинэчлэхтэй холбоотой 4 тэрбумын төсөл улсын хөгжлийн төлөвлөгөөнд явж байсан.

Ер нь төрийн аудитын байгууллагын улсын төсвийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулаад болж өгвөл бид гаднын хөнгөлөлттэй зээл, тусламж, ялангуяа хөгжлийн байгууллагуудтай хамтарсан энэ хүрээнд хэрэгжүүлье гэдэг агуулгаар бид саналаа хүргэсэн.

Төрийн аудитын байгууллагад байгаа шалгагдагч этгээдүүдийн мэдээллийг бид улсын бүртгэлийн нэгдсэн системтэй уялдаж интеграц хийх замаар авдаг.

Төрийн аудитын байгууллага одоо энэ цахим шилжилттэй холбоотойгоор удахгүй Кибер аюулгүй байдлын зөвлөлтэй хамтран өөрийн мэдээллийн системийнхээ аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийлгэнэ. Одоо гишүүдийн, ялангуяа Улсын Их Хурлаас тавьж байгаа энэ шаардлагыг бид анхаараад, болж өгвөл эрхэм гишүүд Та бүхэн манай систем, ялангуяа цахим шилжилттэй холбоотой асуудал дээр улсын төсвийн хөрөнгөөр шийдэх асуудал дээр анхаарч өгнө үү гэдэг хүсэлт байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ч.Анар гишүүн тодруулъя. Асуултад хариулсан уу, үгүй юу?

Ч.Анар: Аудитын газар. Улсын төсвөөс тавих шаардлагатайг нь ойлгож байна. Аюулгүй байдлын зүгээс.

Тэгэхээр миний асуулт нь одоо гадаадын тусламжаар гээд ороод ирсэн байгаа шүү дээ.

Тэгэхээр гадаадын санхүүжилт, хөнгөлөлттэй зээл юм уу, эсвэл гадаадын тусламжаар систем хийж өгөх гээд байгаа юм уу? Энэ чинь өөрөө бид нарын мэдээллийн аюулгүй байдал, улсын аюулгүй байдалд нөлөөлөхөөр нухацтай систем учраас тэрийг тодруулж асууж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: 9 номерын микрофон.

3.Цэнджав: Бид санал хүргүүлэхэд “гадаадын зээл, тусламжаар” гэсэн.

Эдийн засаг, хөгжлийн яам дээрээс нэгтгэл хийгдээд Их Хуралд хүргэгдэхдээ “гадаадын тусламжаар” гэж орсон байна лээ.

Ер нь манай мэдээллийн технологийн шилжилттэй холбоотой Төрийн аудитын тухай хуульд мэдээллийн технологийн төвтэй байх, “мэдээллийн эх кодыг авч ашиглахтай холбоотой асуудлаар мэдээллийн аюулгүй байдал, энэ асуудалд анхаараад үүнийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Одоо яг ийм тодорхой нэг тусламж, зээлээр санхүүжнэ гэсэн юу бол тодорхойгүй байгаа. Тийм төсөл бүрэн гараагүй байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ц.Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Би чинь Ч.Анар гишүүнээс асууя гэсэн чинь Ч.Анар гишүүн маань өөрөө асуугаад байх юм. Ажлын хэсгийн ахлагч гэж ойлгосон чинь тэгээд хэнээс асуухаа сайн мэдэхээ больчихлоо. Тэгэхдээ болно биз дээ. Та ажлын хэсгийн ахлагч учраас. Харин тэгж ойлгосон.

Төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх процессын дахин инженерчлэл гэдгийг би буруу ойлгож байж магадгүй. Төрийн үйлчилгээг технологийн дэвшлийг ашиглаад ямар богино хугацаанд амар хялбар аргаар иргэнд үзүүлэх үйл ажиллагааг хэлээд байгаа гэж ойлгож байгаа. Зөв үү, үгүй юу?

Тэгэхдээ энэ үйл ажиллагааг хаанаас эхлэх вэ гэдэг. Би харах нь ээ энэ бол Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнээсээ эхлэх ёстой юм болов уу гэж

хараад байгаа юм. Энэ яам, агентлагийн бүтэц, бүрэлдэхүүнээс эхлэх юм болов уу гэж хараад байгаа юм.

Ядаж л наад зах нь энэ олон яамдууд дээр энэ инженерчлэлийг хийж, энэ судалгааг хийж, чиг үүргийн давхардал хаана байна вэ гэдгийг нь гаргаж ирмээр байгаа юм. Тэгж байж Засгийн газарт өөрт нь чиглэл өгөөд танай ажлын хэсэг. Одоогийн байгаа Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн ажил үүргийн чиг давхардал ийм байна.

Ядаж л Барилга, хот байгуулалтын яам байж байхад хажууд нь 20 минутын хот Үндэсний хороо ч гэх шиг. Тийм үү.

Тэгээд л Засгийн газар байж байхад л ахиад л Хяналт шалгалт хэрэгжүүлэх агентлаг гээд л. Тэгээд л боомт хариуцсан сайд гээд.

Энэ болгон чинь өөрөө энэ төрийн үйлчилгээ, энэ бүтэц, бүрэлдэхүүнд энэ ажил үүргийн чиг үүрэг. Тэгээд үүнийг дагаад л дандаа яам, агентлаг, төрийн албан хаагчид, одоо нөгөө данхар бүтэц гээд яриад байгаа чинь л энэ шүү дээ. Төрийн үйлчилгээ данхайгаад байна.

Тэгээд доошоо яривал зөндөө юмнууд байгаа.

Тийм учраас би бол энэ ажлаа эхнээс нь энэ бүтэц, бүрэлдэхүүнээсээ хийгээч ээ. Энэ дээрээ үнэлгээ дүгнэлт гаргаач ээ. Таны танай ажлын хэсэг.

Яг энэ Засгийн газрын 15, 16 яам. Одоо яамгүй байгаа сайд нар. Энэ дээр нэг үнэлгээ дүгнэлт гаргаад яг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн ажил, үүргийн чиг давхардлаар ийм байна. Энэ ажлыг жишээ нь энэ энэ яам хариуцаж байхад энэ энэ бас асуудал хариуцсан улсууд. Ажлыг бүр ингээд хоёр, гурав хуваагаад хэн нь эцэст нь хариуцах юм? Дараа нь хариуцлагыг нь хэн хүлээх юм? Энэ асуудал чинь өөрөө тодорхойгүй болчхоод байна шүү дээ.

Эндээсээ тодорхой болгох асуудлыг танай ажлын хэсэг энэ дээр ажиллах ёстой юм биш үү?

Одоо тэрнээс доошоо төрийн анхан, дунд шатанд ажил, үүргийн чиг үүрэг, ажилтай давхацсан хэдэн төрийн албан хаагч нар л байж байгаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Тэгээд энэ ажил үүргийн чиг үүргийг яаж уялдуулах вэ? Давхардуулахгүй яаж байх вэ? Технологийн дэвшлийг яаж ашиглах вэ? /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Та одоо яг загатнасан газар майжиж байна л даа. Яагаад гэхээр энэ процессын дахин инженерчлэл гэдэг юмыг судлаад, манай ажлын хэсгийн захирамж болохоор дахин инженерчлэлийн арга зүйг нэгдсэн арга зүйгээр хангах санал, дүгнэлт гаргах.

Үүнийхээ хүрээнд бид цаашаагаа судлаад явахаар яг таны ярьж байгаа асуудал руу ороод байгаа байхгүй юу. Засгийн газрын бүтэц ямар байх ёстой юм. Ямар бүтэцтэй байх ёстой юм. Давхардсан чиг үүрэг нь юу байх ёстой юм. Төрийн бүтээмж, процессын дахин инженерчлэл гээд улам данхайлгаад байгаа асуудал гарч ирээд байгаа байхгүй юу.

Энэ нь бүр цаашлаад төрийн үйлчилгээ буюу төр ямар үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид хүргэх ёстой юм. Төрийн үйлчилгээ гэдэг маань юу юм бэ гэдэг асуудал руу хүртэл орсон.

Тэгээд өнгөрсөн хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, манай ажлын хэсэг ч гэсэн төрийн үйлчилгээ гэдгийг тоолох гэж үзсэн. Тэгээд тоолох гээд үзэнгүүт төр 900 гаруй төрлийн үйлчилгээ нэг тооллогоор. Зарим тооллогоор 5 мянга гаруй төрлийн давхардсан чиг үүрэгт үйлчилгээ хүргэж байгаа байхгүй юу.

Гэтэл яг төр гэдэг нь өөрөө ямар институцийг хэлж байгаа юм. Иргэн, аж ахуйн нэгж улсдаа ямар үйлчилгээ хийх ёстой юм. Юуг нь хийх ёсгүй, хувийн хэвшлээрээ хийлгэх ёстой гэдэг зааг чиг үүрэг нь байхгүй.

Тэгэхээр үүнийг бас олон улсын жишгээр судалж үзсэн.

Олон улсад зарим улс нь тухайлсан хууль гаргаад нийгэм, эдийн засгийн болон дэд бүтцийн төслийг төр нь хийнэ. Тухайн улс нь геополитик болон хүн ам зүй, нийгэм, боловсролын түвшнээсээ хамаараад үүнийгээ “хийнэ”, “хийхгүй” гээд ялгасан байдаг юм байна. Манайд энэ ялгасан асуудал байхгүй.

Тийм учраас төр өнөөдөр бяслагийн үйлдвэртэй байна, оёдлын үйлдвэртэй байна, өөрснөө уурхай ухаж байна.

Тийм асуудлууд руу орсон байгаа юм. Энэ асуудлыг нь ажлын хэсгийн захирамжийн чиг хүрээнд хийх гэхээр болохгүй байгаа.

Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд Та бүхэнд үүнийг дүгнэлт дээр танилцуулсан. Өөрөөр хэлбэл хамгийн суурь асуудал нь таны хөндөж байгаа засаглалын бүтэц, давхардсан чиг үүрэг юм байна. Үүнийг өөрчлөхгүйгээр процессыг нь дахин инженерчлэл гэдэг бол хоосон баримт бичиг болно. Үүнээс үүдээд маш их замбараагүй, үр дүнгүй худалдан авалт, цахимжилт явагдана. Тантай санал нэг байна.

Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооноос таны саналын дагуу, бидний дүгнэлтэд гэсэн байгаа. Илүү удирдамж өгч дахин үүн дээр зайлшгүй анхаарч үзэх ёстой л гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ц.Сандаг-Очир гишүүн тодруулна.

Ц.Сандаг-Очир: Би зүгээр та бүхний цаашдын ажилд бас хэрэг болох болов уу гээд зүгээр ганцхан кэйс л ярья.

Манай нийслэл байна. Нийслэл Улаанбаатар хот. Нийслэлийн захирагчийн ажлын алба. Энэ дээр та бүхэн анхаараарай.

Сая Хотын дарга хэд хэдэн нийслэлийн агентлагуудыг татан буулгасан. Би үүнийг маш зөв гэж бодож байгаа юм. Нийслэлд одоо яг яамны агентлагуудын доор нийслэлийн агентлагууд байгаа. Тэгээд дүүргийн агентлагууд байгаа. Ингээд нийслэлийн агентлагуудыг харахаар яг шийдвэр гаргаад байгаа юм уу гэхээр шийдвэр гаргаж байгаа юм ерөөсөө байхгүй. 9 дүүргийн судалгаа юмнуудыг авч байгаад нэгтгэж байгаад л уламжилдаг. Энэ бол нэг шатны төрийн хүнд суртал гэж би хараад байгаа юм.

Гэтэл бүхэл бүтэн улсын хэмжээнд хариуцаж байгаа яам нь яг үнэнийг хэлэхэд бүтэц, орон тоо нь бага байдаг юм билээ шүү дээ. Хүн хүрэлцээ байхгүй. Нэг бүхэл бүтэн улсын хэмжээний асуудлыг хариуцаж байгаа яам 50, 60 хүний орон тоотой байгаа.

Тэгвэл би юу гэж бодоод байгаа вэ гэхээр нийслэлийн тэр асуудал... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулах уу? Кэйстэй холбоотойгоор. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Ц.Сандаг-Очир гишүүн ээ, тантай санал нэг байна. Гэхдээ бид Засгийн газрын үйл ажиллагаанд Их Хурал оролцох эрхгүй.

Тэгэхээр Засгийн газар нь тухайн мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй байх вэ? Тэр утгаараа бид үндсэндээ Байнгын хороодоос чиглэл, тогтоол гаргаж энэ асуудлаа цэгцлэх эрх зүйн тийм хэмжээнд л ажиллах боломжтой байгаа.

Тийм учраас Та бүхэн энэ дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд маань санал шүүмжээ, санал, дүгнэлтээ манай ажлын хэсэг дээр өгөөд, бид нэгтгээд Байнгын хороондоо өгье. Баярлалаа. Таны саналыг авлаа.

Ж.Бат-Эрдэнэ: Б.Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Мэдээлэл хийсэн дарга нарт бас баярлалаа. Нэлээн чухал асуудал хэлэлцэж мэдээлэл өгч байгаа.

Энэ олон жил яригдсан юм. Тэгээд өнөөдөр ингээд хоёр Байнгын хороо хамтраад хуралдаж байна. Хоёр Байнгын хорооны дарга сууж байна.

36 гишүүнээс өнөөдөр энд 6 гишүүн байна. Энэ парламентад орж ирээд тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооныхоо хуралд суух үүрэгтэй. Одоо тэгээд сүүлдээ бараг орж ирээд ирцдээ ороод өгөөч гэж гуйдаг хэмжээ рүү очиж байна шүү дээ.

Одоо ажлын хэсгийн гишүүдээ хар л даа. 20 хэдэн хүн сууж байна. Тэгэхэд энд бид 5, 6-хан сууж байдаг. Тэгээд цаашдаа Монгол төрийн ажил чинь ингэж явдаг байх юм уу? Болно оо, бүтнэ ээ, хийнэ ээ, хэрэгжүүлнэ ээ, алаад өгнө өө л гээд л орж ирсэн шүү дээ ер нь бүгд.

Тэгэхээр энэ дээр ийм байна. Ажлын хэсэг мэдээж мэргэжлийн түвшинд сайн ажиллаад л ирсэн байх. Одоо жишээлбэл ингээд ажлын хэсгээ хар та нар.

Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал хоёроо жоохон ялгаж салгамаар байна шүү. Өнөөдөр хууль тогтоох байгууллага буюу Их Хурлаас сонгогддог, томилогддог албан тушаалтнууд, гүйцэтгэх засаглалын албан тушаалтнууд холилдоод суучихсан. Энэ чинь эрх мэдэл, чиг үүргийн хувьд шал ондоо шүү дээ.

Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн албаны зөвлөл, аудит, статистик шууд иргэнд үйлчилдэг байгууллага биш шүү дээ. Эд нар чинь.

Тэгээд төрийн албаны реформ хийнэ гээд бид өмнө нь ярьсан. Үндэсний хөгжлийн яамны манай дарга байж байгаа. 2026 оны хөгжлийн төлөвлөгөө дээр 9 хувь бууруулна гээд шууд тоо тавиад ороод ирж байгаа. Тэгээд яаж бууруулах юм бэ гэхээр хариулж чаддаггүй. Данхар бүтцээ ер нь яаж багасгах юм. Энэ чинь өөрөө дахин инженерчлэл байхгүй юу.

Дахин инженерчлэлээ ойлгохгүй байж баахан төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан л байна лээ шүү дээ. Тэгээд энэ дээр хэн хариуцлага хүлээх юм.

Тэгээд сая та бүхний хийж байгаа мэдээллийг харахаар бүгд ялгаатай мэдээлэл хийж байна шүү дээ. Ойлголт буруу зөрүүтэй л байна. Энэ чинь миний яриад байгаа нөгөө засаглалынхаа эрх мэдлийг эхлээд ялгаач ээ л гээд байгаа шүү дээ. Цаашдаа хууль тогтоох, гүйцэтгэл хоёр нь холилдоод яваад байх юм уу.

Төрийн албаны реформ чинь энэ байхгүй юу даа. Үүнийгээ засаж байж бид дахин инженерчлэлийнхээ асуудлыг ярихгүй бол наадах чинь дахиад л бид хаданд хашхирсантай л адилхан л юм болно. Төсвийн хөрөнгө нь элсэнд асгасан ус шиг л шингэнэ.

Тэгэхээр эдгээр зүйлүүдээ нэлээн нухацтай харж үзмээр байна. Би 1 минутаа... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Б.Баярбаатар гишүүн 1 минутыг нэмж өгье.

Б.Баярбаатар: Төрийн албаны реформоо бид эхлээд хийхдээ данхар бүтцээ бууруулахын тулд эхлээд нэгдүгээрт хууль тогтоох, гүйцэтгэх гэсэн ялгаагаа гаргаж тавина. Дараа нь төрийн үйлчилгээ, тэгээд дараа нь хяналт, тэгээд үр дүн. Ерөөсөө л инженерчлэл чинь энэ байхгүй юу.

Тэгэхээр эдгээр зүйлүүдээ системчилж байж байгаад явахгүй бол дахиад үр дүнгүй баахан зүйл гарах вий дээ. Нэгд баталсан тогтоол маань хэрэгжихгүй тогтоол Их Хурлаас гарах вий дээ гэдэг ийм болгоомжлол байна.

Тэгэхээр дахин үүнийгээ сайн ажлын хэсгийн түвшинд системчилсэн нь зөв байх гэсэн саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ч.Анар гишүүн хариулах юм уу? Санал уу? Санал.

Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Ер нь ажлын хэсгийн дүгнэлт дээр ч дурдагдаж байна, гишүүд ч гэсэн хэлж байна.

Ер нь яг энэ ажлын хэсгийн даалгавар маань юу билээ? Энэ даалгаврын хүрээнд дахин инженерчлэл буюу процессын дахин инженерчлэл дээрээ бид яг юуг ойлгоод байгаа юм? Тэр нэгдсэн ойлголт маань байхгүй байна. Тийм ээ.

Энэ дээр бас нэг юмыг тодруулж ойлгомоор байгаа зүйл нь бид ажлын хэсэг бол ерөнхийдөө “төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл” гэж уншигдаад байгаа юм.

Тэгэхээр төрийн үйлчилгээ гэдэг бол илүү иргэн рүү чиглэсэн болохоос төрийн байгууллагуудын хоорондын ч юм уу, эсвэл төрийн байгууллагын өөрийнх нь процессын асуудал бас шууд орж ирэхгүй байгаа байхгүй юу. Яг үйлчилгээ тал руугаа яваад байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ бас хэдүүлээ нэг талд нь гаргаад, яг төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл нь үйлчилгээ талдаа яваад байна уу? Эхний ээлжид бид яг ямар үр дүн гаргах юм? Одоо бүтэн засаглалын

хэмжээнд буюу Засгийн газрын үйл ажиллагааны хоорондын нийцэл тийм ээ, яг аль, хаанаа чиг үүрэг давхардаж байна гэдэг энэ юмнууд ороод ирэх юм бол энэ нэлээн том хүрээний ажил болно.

Тэгэнгүүт хамгийн эхний ээлжинд жишээлбэл төрийн үйлчилгээн дээрээ бид засаж болох, богино хугацаанд засаж болох юмнууд дээр засвар хийгдэхгүй, төрийгээ хийж чадахгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр ажлын хэсгийн дүгнэлт дээр байна л даа. Төрийн мэдээллийн нэгдсэн бүртгэл сан байхгүй, иргэний нэгдсэн данс байхгүй учир мэдээллийн нэгдмэл байдал, давтагдашгүй байдал хангагдаагүй болно. “Хур” системийн ард нэгдсэн өгөгдлийн сан байхгүй бөгөөд төрийн байгууллагуудад доор бүрнээ хөгжүүлэлт тус тусдаа ашиглагдаж буй 152 бүртгэлийн мэдээлэл, өгөгдлийн бааз холбогдон ажиллаж байгаа нь төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагааг дэмжих нэгдмэл байдал хангалтгүй. Ингэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ өөрөөр хэлбэл юу вэ гэхээр бид өнөөдөр e-mongolia-гийн тайлбар буюу e-mongolia дээр ийм хэмжээний иргэдээс хүсэлт ирсэн байна, энэ хэмжээний үйлчилгээг үзүүлсэн байна гэж байгаа юм. Гэтэл үүний чинь хэдэн хувь нь төрийн байгууллагад аваачиж өгөхийн тулд тэр лавлагаа, тодорхойлолтыг авсан юм бэ буюу тэр төрийн мэдээлэл хоорондоо солилцох боломжтой байтал яг тэндээс очоод киоскоос мэдээлэл аваад төрийн байгууллагад хүргэж өгч байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нөхцөл байдал чинь арилах ёстой. Тэгж байж бид дараа дараагийн инженерчлэлийн тухай ярих ёстой. Гэтэл өнөөдөр процесс нь өөрөө дахин инженерчлэл байтугай зүгээр процессын сайжруулалт хийж чадахгүй суугаад байна шүү дээ. Тэгэхээр энэ тал дээрээ анхаармаар байна.

Нөгөө талдаа яг энэ дээр жишээлбэл блокчэйн, цахим засаглал гэдэг юм яагаад гарч ирсэн юм бэ? Яагаад гэвэл энд нэгдсэн дата баазтай байх, төрийн байгууллагууд яг тэр блокчэйн дээр байгаа мэдээллийг өөр өөрсдийн хүрээнд татаад авах боломжтой байх энэ блокчэйн цахим засаглалын ажлын даалгавар оччихоод байтал энэ нь тэг хувь буюу үр дүнгүй гээд үнэлэгдсэн байж байгаа юм.

Тэгэхээр бид энэ байдлууд дээрээ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут Г.Уянгахишиг гишүүнд. 1 минут өгье.

Г.Уянгахишиг: Тэгэхээр бид энэ мэтчилэн наад захын юмнуудаа хийхэд яг юу дутаад байна вэ? Боломж нь юун дээр гацаад байна вэ гэдгийг бас мэдмээр байгаад байна.

Өөрөөр хэлэх юм бол санхүүжилт нь болохгүй байгаад байна уу? Эсвэл үнэхээр хүний нөөцийн дутмагшил байгаад байна уу? Эсвэл ерөөсөө яг юу хийх ёстой ойлголт нь байхгүй байгаад байна уу?

Тэгээд нөгөө талаасаа одоо бид яг энэ ажлын хэсгийн үйл ажиллагааг цаашаагаа дэмжээд явах хүрээнд юу хийх юм бэ гэдэг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо, Цахим бодлогын байнгын хороо хамтран хэлэлцэж байгаа бол яг энэ ажлын хэсэг буюу Засгийн газар өөрөө, Засгийн газрын нэгжүүд болон Их Хурлын байгууллагууд зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд, өөрийнхөө чиг үүргийн хүрээнд л ажиллах боломж буюу хайрцаглагдаад байна гэж байгаа бол энэ ажлын хэсгийн хүрээнд яг ямар байдлаар хамгийн сайн хувилбар нь байж чадах юм. Үүнийхээ хүрээнд бид эрх зүйн шинэчлэлтүүд дээр юуг анхаарах юм гэдэг юм бас гарч ирэх байх гэдэг хүлээлттэй байна. Зөв үү? Тийм ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Түрүүний ирц дээр Э.Батшугар гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, С.Цэнгүүн гишүүн нар нэмэгдэж ирсэн байна.

Ч.Анар гишүүн хариулт өгье.

Ч.Анар: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Төрийн үйлчилгээний гээд манай захирамж тэгээд гарсан байгаа боловч үндсэндээ нөгөө төрийн процессын дахин инженерчлэл гэдэг юу юм. Зарим томъёоллоор энэ их түвэгтэй нэр томъёо учраас “төрийн бүтээмж” гэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэрлэж байгаа. Гэхдээ аль нь яг зохистой вэ гэдэг энэ нэр томъёо дээр хүртэл бид хэлэлцүүлэг өрнөж байгаа юм.

Тэгэхээр нөгөө онолоороо дэлхийн улсуудад амжилттай хэрэгжсэн улсууд байна, амжилтгүй хэрэгжүүлсэн улсууд байна. Энэ хүссэн хүсээгүй л бид хийнэ. Тэр ч утгаараа манай бүх мөрийн хөтөлбөрүүд орсон.

Тэгэхээр өнөөдөр бид e-mongolia буюу төрийн үйлчилгээг иргэндээ, харилцагчдадаа хүргэдэг цахимжилтын системийг амжилттай нэвтрүүлсэн. Энэ бол маш том суурь сэтгэлгээний өөрчлөлтийг авчирсан. Гэхдээ энэ маань төрийн процессын дахин инженерчлэлийн зөвхөн нэг хэсэг.

Та бүхэнд тараагдсан дүгнэлт дээр байгаа. Төрийн процессын дахин инженерчлэл гэдэг нь

- төр, иргэн хоорондын харилцаа,
- төр, төрийн байгууллага хоорондын харилцаа,
- төр, аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа,
- төр, төрийн албан хаагчдын харилцаа

гэдэг харилцааг зохицуулж байж бид эцсийн үр дүндээ хүрч чадна.

Тэгэхээр энэ бол зөвхөн төр иргэндээ хүрч байгаа үйл ажиллагаа биш юм. Түрүүн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас дурдаж байгаа лицензийн асуудлууд байна. Эргээд төрийн байгууллагуудын бүтээмжийн асуудал.

Өнөөдөр манай төрийн байгууллагын өндөр мэргэжлийн албан хаагчид маань Их Хурлын Байнгын хороод ажлын хэсгийн хурлууд дээр өдөржингөө суугаад нэг л асуултад хариулдаг. Энэ нь ч гэсэн ялгаагүй процессын дахин инженерчлэл.

Яг иргэн өөрт, төрд байгаа мэдээллээ төрөөс нийгмийн даатгал, татвар, цагдаа гэж аваад, цуглуулж аваад буцаагаад нэг төрийн байгууллагад өгөөд төрийн үйлчилгээ аваад байгаа байхгүй юу. Энэ нь эргээд нөгөө хууль эрх зүйн ойлголт нь байхгүй.

Яг түүнтэй адилхан бид болж байгаа мэдээллийг Засгийн газрын яам харьяа хэрэгжүүлэгч газруудын дарга нарыг суулгаж байгаад гишүүд бүтэн өдөржин ганц л асуултаа асууж байгаа юм. Энэ нь бидний төрийн процесс бас буруу байна л гэсэн үг байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө бүтээмж маш муу.

Тэгэхээр энэ дээр та дараагийн асуулт нь юу нь болохгүй байгаа юм бэ гээд асууж байна шүү дээ.

Тэгэхээр анх энэ ажлын хэсгийг ахалж байгаагийн хувьд төрийн процессын дахин инженерчлэл гэхээр ажлын хэсгийг ахалж байгаа гишүүний хувьд ч гэсэн би үүнийг “технологи, инновац” гэж ойлгосон боловч энэ бол хамгийн суурь асуудал нь “засаглалын бүтэц” юм байна. Цаашлаад энэ өөрөө хууль, эрх зүйн гажуудал байна. Хуучин ийм байхаас ч өөр аргагүй. Улс орнуудын хөгжил, нийгмийн чиг хандлага өөр байсан. Дэлхийн бүх төрийн үйлчилгээ хяналт суурьтай байх ёстой байсан... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэх үү? Тэндээс нэмье гээд байгаа юм уу? 1 номер.

Өөрийгөө танилцуулаарай. С.Тэнгис үү? 1 номер.

С.Тэнгис: Түрүүн бас Ц.Сандаг-Очир гишүүн асууж байсан.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуул.

С.Тэнгис: Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн ажлын албаны дарга С.Тэнгис.

Засгийн газар дээр чиг үүргийн шинжилгээгээ хийгээрэй гэдэг даалгавар манай зөвлөлийн ажлын албанд өгөгдсөн. Тэгээд чиг үүргийн шинжилгээ эхний ээлжид Боловсролын яамтай хамтарч ажиллаад яг одоо Ц.Сандаг-Очир гишүүний дурддаг тэр Нийслэлийн боловсролын газар, Дүүргийн боловсролын газрууд болон Боловсролын ерөнхий газар байгуулагдсантай холбоотой судалгааг хийж үзээд 78 чиг үүргийн давхцал гарсныг илрүүлсэн.

Энэ 78 чиг үүргүүдийг ерөнхийд нь дүүргүүд рүү хуваарилаад, үүний үр дүнд боловсролын салбараас 30 хүний орон тоог цомхотгох боломжийг гаргаж ирж байгаа юм.

Тэр 78 чиг үүрэг юу байсан бэ гэхээр ерөөсөө Боловсролын ерөнхий газар, нийслэл хоёр дээр дүүргээсээ тоо нэхдэг хүний тоо нь нэмэгдээд, яг дүүрэг дээрээ сургуультай харьцдаг ерөөсөө хоёр, гуравхан хүн байсныг бүгдийг нь дахиж хуваарилаад Засгийн газарт танилцуулаад бид шийдвэр гаргуулсан.

Г.Уянгахишиг гишүүний асуусан... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Г.Уянгахишиг гишүүний асуултад 1 номер.

С.Тэнгис: Дахин инженерчлэлийг яг төрийн үйлчилгээ гэж дангаар нь авч үзэх гэхээр нөгөө төрийн үйлчилгээ чинь зөвхөн иргэнээс хүсэлт авч байгаа хэсэг дээр очоод зогсчхож байгаа. Тэгэнгүүт тэрийг шийдвэрлэж байгаа процесс нь өөрөө төрийн байгууллага дотроо, эсвэл нөгөө хүнээс мэдээлэл, лавлагаа шаардахгүйгээр хоорондоо байгаа мэдээллийг солилцоод үйлчилгээ үзүүлбэ гэхээр нөгөө төрийн байгууллага хоорондын процессын бас асуудал үүсэж байгаа учраас яалт ч үгүй энэ ажлын хэсэг чиг үүрэг нь өргөжөөд, төрийн процессын дахин инженерчлэл болчихоод байгаа.

Е-Mongolia дээр ч гэсэн бас тэр лавлагаа, тодорхойлолтыг нэг газраас нөгөө газарт иргэн өөрөө л лавлагааг нь авч очдог нэг ахиц гарсан. Үүний дараагийн шат буюу e-mongolia дээр процессын дахин инженерчийг хийе гэвэл ерөөсөө e-mongolia-гийн үйлчилгээний тоо нь өсөх биш харин эсрэгээрээ бараг буураад 0 болж болж байвал дахин инженерчлэл хийсэн гэж үзэхээр болж байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Саяын тайлантай холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгье. С.Цэнгүүн гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Ж.Бат-Эрдэнэ.

Ц.Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр Ч.Анар гишүүн ээ, танай ажлын хэсэг дүгнэлтээ хэзээ гаргах юм. Энэ ер нь манай Хууль зүйн байнгын хороон дээр хууль эрх

зүйн том шинэчлэл гэж ярьдаг. Тэгвэл төрийн байгуулалт дээр танай хийж байгаа энэ ажил бол төрийн албанд маш том өөрчлөлт, хувьсгал гэх нь хаашаа юм. Ийм том өөрчлөлт гарахаар юм байна шүү.

Энэ судалгааны үнэлгээ дүгнэлттэй ажлаа маш сайн боловсруулж хийж чадвал, дүгнэлтээ бодитой гаргаж чадвал манай төрийн албанд бугшаад байгаа, бид бүхний олж харахгүй байгаа төрийн ажил, үйлчилгээний давхардал, хийдэл, нөгөө талаас иргэнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл энэ болгон дээр өөрчлөлт, ахиц дэвшил гарах суурь эндээс харагдаж байна.

Тийм учраас би Та бүхний танай ажлын хийж байгаа ажлын хэсгийн судалгаа, дүгнэлт цаг алдалгүй яаралтай орж ирэх хэрэгцээтэй байна. Гагцхүү харин танай хийсэн судалгааг Улсын Их Хурал онцгой ач холбогдол хандуулж, цаашдаа Засгийн газарт чиглэл өгч тогтоол гаргаж, энэ хүрээнд олон төрийн бүтцүүдийн давхардал хийдлийг гаргах. Энэ нь цаанаа өөрөө төрийн том данхар бүтэцтэй шууд холбоотой. Нөгөө талаар ажил, үүргийн давхардал, нөгөө талаар тэрийг дагасан олон чиг үүрэг давхцаад, одоо сая тэр албан тушаалтан хэлж байна шүү дээ. Энэ чинь өөрөө эргээд төрийн ажлыг хүнд суртлын бий болгоод байна. Бий болгоод байна.

Тийм учраас энэ судалгааг гаргаж чадвал төрийн маш сайн бүтцийг бий болгох, дагаад иргэнд төрийн үйлчилгээ, одоо тэр түргэн шуурхай, зардал чирэгдэл багатай, хурдан шуурхай үзүүлэх тэр бололцоо боломжууд нээгдэх юм байна л гэж би хувьдаа харж байна.

Тийм учраас танай ажлын хэсэг маш сайн ажиллаж яаралтай дүгнэлт юмаа оруулж ирж Улсын Их Хурал дээр Засгийн газарт чиглэл өгүүлэх асуудал дээрээ онцгой анхаарал хандуулж ажиллах шаардлагатай юм байна шүү л гэж би хувьдаа хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: С.Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Төрийн процессын дахин инженерчлэл ажлын хэсэг дээр яригдаж байгаа зүйл бол ихэвчлэн ерөнхийдөө иргэн рүү чиглэсэн байдалтай гарсан байгаа юм.

Тэгэхээр GOVERNMENT TO BUSINESS буюу бид аж ахуйн нэгжүүд, бизнесүүдтэйгээ яаж төр маань харилцаж байгаа юм бэ, тэр харилцаа холбоо маань өөрөө хэр ойлгомжтой байгаа юм бэ гэдгийг зайлшгүй ярих шаардлагатай. Манай төр өөрөө зөвхөн цахим хуудас гэхэд 1416 цахим хуудсаар дамжуулж мэдээллүүдээ хүргээд байгаа юм. Яам, агентлагууд. Гэтэл мэдээлэл нээлттэй юм шиг хэрнээ тэр олон цахим хуудаснууд дундаас бизнес эрхлэгч нар маань өөртөө хэрэгтэй мэдээллийг олж авна гэдэг хэцүү.

Тэгэхээр нэгдсэн байдлаар мэдээллийн сүлжээгээ нэгтгэнэ гэдэг нь аягүй чухал байгаа юм.

Дээрээс нь бас нэг анхаарууштай зүйл нь яагаад ер нь манай төр ийм данхар бүтэцтэй болсон юм бэ гэхээр маш олон тусгай зөвшөөрөл болон төрөөс авах ёстой хяналтын үйл ажиллагаа хийх гэж байна гэдэг нэрийдлээр бизнес эрхлэгч нарыг дарамталдаг энэ систем чинь л өөрөө томорсон учраас болоод байгаа.

Тэгэхээр Барилга, хот байгуулалтын яаман дээр Ж.Батсуурь сайд сая шинэ нэг мэдэгдэл гаргасан байсан. Тусгай зөвшөөрлийг авах үйл явц, процессыг хялбарчлаад цахимаар өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх боломжтой болгож гаргасан.

Тэгэхээр үүнээс маш том бусад яамд ч гэсэн энэ жишгийг баримтлаад өөрчлөлтийг хийх боломж нь харагдаж байгаа.

Тэгэхээр энэ G-to-B буюу бизнес эрхлэгч нар дээр процессын инженерчлэл маань яаж хийгдэх юм бэ? Энэ дээр процессоо бид маш сайн ойлгомжтой болгоод төр өөрөө бизнес эрхлэгч нарт дарамт болдоггүй байх гэдэг үндсэн зарчмаа баримталж явахгүй бол бид бизнес эрхлэгчдээ дандаа орхигдуулж хаягдаж явж байгаа.

Тэгэхээр манай Монгол Улсын би DOING BUSINESS индекс маань жил болгон уруудаад байгаа буюу бизнес эрхлэх минь өөрөө бараг одоо маш одоо ашигтай ажиллаж чадах хэмжээ гэдэг нь өөрөө хүнд болоод, зүгээр нэг төрийн бус ажиллуулж байгаа юм шигээр л татвараас татварын хооронд бизнес эрхлэгч нар маань ажилладаг болчихоод байгаа.

Тэгэхээр бизнес эрхлэгч нарын ашигт ажиллагааг сайжруулах, төр өөрөө дэм болж тус болдог болох тэр процессыг бид зайлшгүй энэ дотроо дагуулж яваасай гэж ажлын хэсгийн дарга Ч.Анараа гишүүнээс хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Б.Хэрлэн гишүүн үг хэлнэ.

Б.Хэрлэн: Тэгэхээр хүн төвтэй PROACTIVE төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх процессын дахин инженерчлэл гэсэн энэ ажлын хэсгийн гишүүний хувьд бас өөрийнхөө байр суурийг илэрхийлье гэж бодож байна.

Тэгэхээр энэ ажлын хэсэг шулуухандаа хэлэхэд өнөөдөр төрийн албанд байгаа бүтэц, зохион байгуулалтыг оновчтой байлгах тухай, төрийн ажил үйлчилгээний процессыг иргэдэд чирэгдэлгүй болгох тухай, төрийн захиргааны шинэчлэлийг түргэсгэх тухай маш их олон асуудлыг хөндсөн их том, нүсэр сэдвийг, ажлыг хариуцаж байгаа ажлын хэсэг байгаа.

Тэгэхээр маш богино цаг хугацаанд ажлын хэсэг тодорхой үр дүнтэй ажилласан. Хамгийн нэгдүгээрт гэхэд ер нь процессын дахин инженерчлэл гэж чухам яг юу юм, өнөөдөр төрийн байгууллагын бүтээмж гэж яг юу юм гэдэг тухай дээр энэ чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг нэгтгэж байна. Ойлголтыг нэгтгэх тал дээр бас нэлээн их дорвитой ажилласан.

Одоо тэгээд энэ ажлын явцад бидний хамгийн анхаарал татаж байгаа нэг асуудал нь ерөнхийдөө процессын дахин инженерчлэлийг ярихын тулд зайлшгүй чиг үүргийн давхардлын тухай асуудлыг ярихгүй бол болохгүй нь ээ гэдэг дээр манай ажлын хэсгийнхэн хамгийн нэгдүгээрт санал нэгдээд байгаа.

Тэгэхээр бүтэц, зохион байгуулалт маань өөрөө оновчтой бус байгаа учраас зарим нэг чиг үүрэг нь орхигдох, давхардах, хийдэх явдлууд их гараад байна. Энэ нь энэ процессын дахин инженерчлэлийг хийхэд сөрөг нөлөө үзүүлээд байна. Тэр тусмаа нөгөө “Хүн төв”-тэй төрийн үйлчилгээг хүргэхэд бас нэлээн сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн ийм дүгнэлтийг манай ажлын хэсгээс хийгээд байгаа.

Тэгээд дараа дараадаа ерөнхийдөө энэ төрийн үйлчилгээг дахин инженерчлэлийн тухай асуудлыг ярихдаа дэлхий дахинд төрийн захиргааны шинэчлэл аль тал руугаа явж байгаа юм. Ялангуяа “ХҮН ТӨВ”-тэй болгохын тулд иргэдэд төрийн үйлчилгээгээ авч байгаа иргэдэд яаж хялбар дөхөм арга замаар төрийн үйлчилгээг хүргэх ёстой юм бэ, ямар ямар шинэ туршлагууд байгаа юм бэ гэдгийг өөрсдөдөө хэрхэн яаж авч хэрэгжүүлэх тухай дээр бид дараа дараагийнхаа ажлыг чиглүүлэх төлөвтэй байгаа.

Тэгэхээр 5, 6 сарын хугацаанд одоо энэ ажлын хэсгийн ажлын үр дүн бол чамлахааргүй ийм үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Хоёр Байнгын хорооны эрхэм гишүүддээ маш их талархлаа.

Яагаад вэ гэхээр “процессын дахин инженерчлэл” гэдэг бол энэ технологийн асуудал биш юм. Энэ нь өөрөө төрийн суурь асуудал, хууль эрх зүйн суурь асуудал.

Түрүүн Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулж чадсангүй. Ямар асуудалд хамгийн том садаа болж байгаа юм бэ гэхээр ерөөсөө л сэтгэлгээний асуудал. Төр иргэндээ үйлчилгээгээ хүрэхдээ хянадаг байх ёстой, бүх юм хяналтын доор байх ёстой л гэдэг сэтгэлгээ.

Энэ нь бид үйлчилгээ хүргэж байгаа. Одоо бизнесийн байгууллагууд бүгд тийм болсон шүү дээ. Хэн нь иргэндээ хурдан шуурхай зардал чирэгдэл,

төвөггүй үйлчилж чадаж байгаа тэр газар л амьд оршин тогтнож, өрсөлдөх чадамжтай байгаа. Ирээдүйд ямар улсын иргэд төрийн төрд итгэх итгэл, төрийн нэр хүнд өндөр байна, төрийн үйлчилгээ нь өөрөө төрийн албан хаагчид нь сэтгэл ханамжтай байна гэдэг маань бүх юм зардал чирэгдэлгүй, ойлгомжтой, тодорхой, хурдан шуурхай л байх ёстой.

Тэгэхээр энэ ойлголт маань гүйцэтгэх хэсэг маань л технологитой холбоотой хэсэг. Түүнээс суурь ойлголт нь бид өөрсдөө сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй.

Тэгэхээр юу дахиад шинээр хоёр Байнгын хорооны гишүүд маань энэ бол сууриараа төр гэдэг үеийн төрийн үйлчилгээ, засаглалын бүтцийг өөрчлөх ёстой гэж санал гаргаж байгаад нь энэ суурь асуудлыг нь ойлгож байгаад ажлын хэсгийн гишүүдийн зүгээс талархалтай хандаж байна.

Манай ажлын хэсгийн хурал, үйл ажиллагаа бол нэгдсэн арга зүйгээр хангах санал, дүгнэлтээ гаргана.

Тэгэхээр үүн дээр үндэслээд Төрийн байгуулалтын байнгын хороо тогтоолоо боловсруулаад энэ ажлын хэсэг цаашдаа Ц.Сандаг-Очир гишүүний ярьж байгаа, С.Цэнгүүн гишүүний ярьж байгаа шиг илүү нарийн зураглал руу орох чиглэл нь Их Хурлын харьяаны чиг үүргийн эрх зүйн хэм хэмжээндээ яаж явах вэ гэдгийг тодорхойлох юм бол бид дахиад хийх ажил маш их байна.

Хамгийн санаа зовж байгаа зүйл бол зайлшгүй хэрэгтэй дэлхийн улс болгон хийж байгаа ч гэсэн гоё нэрийг ашиглаж маш их үргүй төсөв үрэгдүүлдэг. Тэгээд үүнээсээ болоод бүтэлгүйтсэн маш олон улсын жишээ байгаа. Бид тэр болгоноос зайлшгүй суралцахгүй бол энэ маань зүгээр нэг гадаад нэр томьёо ашигласан ажил биш юм шүү гэдгийг Та бүхэнд хэлэхийг хүсье. Баярлалаа. Та бүхэнд.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд үг хэлж дуусаж байна. Би таван үг хэлээдэхье.

Төрийн үйлчилгээний инженерчлэл гэдэг асуудлыг бид нэлээн томоор нь харах ёстой юм. Төр хэн рүү үйлчилж байгаа, төрийн үйлчилгээ гэж юу юм бэ гэдэг бол угаасаа ард түмэн, иргэдэд үйлчилж байгаа үйлчилгээ.

Тэгэхээр энэ захирамж дээр хэлж байгаа шүү дээ. Төрийн үйлчилгээг хүн төвтэй болгох гэсэн асуудал. Сая гишүүд ч ярилаа, ажлын хэсгийнхэн ч ярилаа. Түүн рүү хандсан ийм төрийн үйлчилгээ байх ёстой.

Дээрээс нь төрийн үйлчилгээний бүтцээсээ авхуулаад үзэх ёстой. Нарийн яривал Үндсэн хуульдаа бид гар хүрэх ёстой юм уу, үгүй юм уу. Тэндээсээ бүтцийн асуудлууд нь яригдах ёстой юм уу. Орон нутгийн хүрээнд өөрөө удирдах ёс маань зөв явж байгаа юм уу, үгүй юм уу. Ингээд харах ёстой.

Сая Ц.Сандаг-Очир гишүүн хэллээ шүү дээ. Бүтэцтэй холбоотой асуудлууд. Ингээд үзэхээр ер нь төрийн үйлчилгээ үзүүлж байгаа төр чинь, төрийн бүтэц чинь өөрөө зөв юм уу гэдэг ийм асуудал гаргаж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье. Тодорхой хэмжээнд өөрсдийнхөө хүрээнд мэдээллээ өгсөн. Өөрсдийнхөө хүрээнд энэ шинэчлэлийг хийж байгаа төрийн албаныхны мэдээллийг бас сонслоо. Нэлээн өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй юм байна. Хэдүүлээ мэдээллүүдээ зөв болгох хэрэгтэй юм байна. Инженерчлэл гэж яг юу хийх ёстой юм. Зүгээр нэг дүрэм журамдаа хийсэн өөрчлөлтийг хэлж байгаа юм уу. Та нарын өөрсдийн ажиллаж байгаа бүтэц чинь зөв юм уу. Энэ бүх өнцгөөс нь бүр томоор нь харах ёстой юм байна гэж харж байгаа юм.

Нэг зүйл хэлэхэд Төрийн нарийн бичгийн Зам, тээвэр, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байхад 98 хүнтэй ажиллаж байсан. Хоёр яам нийлээд шүү дээ.

Сүүлд нь Зам, тээвэр, хөгжлийн яаман дээр очиход 140 хүнтэй. Зөвхөн нэг яам нь 140 хүнтэй ажиллаж байсан шүү дээ.

Тэгээд энэ юуг хэлээд байна гэхээр хэн лоббитой, хэн илүү хөдөлгөөнтэй байдаг юм уу, сайд нь өөрсдийнхөө бүтцийг батлуулахдаа ингээд батлуулдаг. Тэгээд энд ямар ч судалгаа байхгүй. Тэгээд ямар давхардал явж байна гэхэд урьд нь хоёрхон хүн ажиллаж байсан иргэний нисэхийн үйл ажиллагааг хариуцаж байсан газар гээд тэгэхэд 8 хүн ажиллаж байгаа шүү дээ. Урьд нь хоёрхон хүн ажиллаад л явж байсан.

Сая Улаанбаатар хот дээр өчнөөн асуудлууд байна гээд ярьж байна. Яамд дээр өчнөөн асуудлууд байна гэж ярьж байна. Тэрний эрх зүйн асуудлууд нь яаж гарах юм.

Ингэхээр маш томоор харах асуудал болоод байгаа юм. Тэгээд ийм чухал асуудал дээр сая Б.Баярбаатар гишүүн хэлж байна. 7, 8 гишүүн л сууж байна шүү дээ. Энэ чинь. 30 гаруй гишүүн байх ёстой.

Бүхэл бүтэн хоёр Байнгын хороо нэгдээд хуралдаж байгаа ийм чухал асуудал дээр цөөхөн хэдэн гишүүд л байж байна.

Тэгэхээр ямар ч байсан одоо гишүүдийн саналыг харгалзаж үзээд дахиад бид ажлын хэсгээс гаргаж ирсэн дүгнэлт дээр үндэслээд Улсын Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзэж байгаа. Улсын Их Хурлын тогтоол гаргаад хоёр Байнгын хороо хамтраад ч юм уу Улсын Их Хурлын чуулган руу оруулаад энэ инженерчлэл гэдэг асуудал дээр тэр зорилго, тэр чиглэл, тэр агууламж бүх

зүйлүүдийг нь хийсэн ийм тогтоол Улсын Их Хурал руу оруулаад батлуулаад, тэгээд үндсэндээ төрийн байгууллагын, төрийн бүтцийн том инженерчлэл, том хувьсгал, том өөрчлөлт болно л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр нэг тийм Улсын Их Хурлаас чиглэл гаргаж өгье. Тогтоолын төсөл Засгийн газар луу гаргаж өгье. Тэгээд тэрийгээ давхар хянаад.

Би түрүүн хэлж байгаа нь яам гээд хэлээд байна шүү дээ. Хоёр яам нийлээд 98 хүнтэй ажиллаж байсан бол нэг яам нь 140 хүнтэй ажиллаад байна шүү дээ.

Тэгэхээр яам бол өөрсдийнхөө үйл ажиллагааг дангаараа хянаад засвар хийнэ гэсэн ойлголт байхгүй. Үүнийг тусгай баг гаргаж байж, Засгийн газар өөрсдөө нэлээн хөндлөнгөөс харсан ийм хэмжээний шинжилгээ судалгаатай баг гарч ирж байж, хаана ямар ямар өнцөг дээр юуг нь өөрчлөх юм, ямар хууль, эрх зүйн орчныг бий болгох юм гэдэг том өөрчлөлт хийх ёстой гэж ойлгож байгаа.

Сая С.Тэнгисийн мэдээллүүд дотор ч бас гарч ирж байх шиг байна. Зөв ойлгохоос авхуулаад гээд. Яг инженерчлэл гэдэг утгаа ямар чиглэлээр бид гаргах юм гэсэн Улсын Их Хурлын чуулганаар оруулах тогтоолын төслийг өргөн барьж чуулганд оруулах нь зүйтэй юм байна гэсэн зүйлийг хэлэхээр байна.

Ж.Золжаргал дарга үг хэлье. Ж.Золжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Золжаргал: Ажлын хэсэг нэлээн хугацаа зарж ажилласан.

Процессын дахин инженерчлэлийн чиглэлээр өнөөдөр мэдээлэл өгсөн ажлын хэсгийнхэн, хэд хэдэн газар зэрэг ажиллаад байгаа. Мэдээж бүх шатны зургийг бүгдийг нь зураад энэ ажлын хэсэг дээр гаргана гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр түрүүн Ч.Анар гишүүн дурдаад байгаа чухал нэртэй, гоё нэртэй ажлын цаана давхардсан ажлууд их гараад байдаг гээд. Тэгээд давхар давхар энд тэнд ажил хийнэ, зарим нь өөр байдлаар нөгөөхөө ойлгоно.

Тийм болохоор ерөөсөө үзэл баримтлалын хувьд энэ хайрцаг нь хаанаа байх юм. Аргачлал боловсруулах гэдэг нь л Улсын Их Хурлын ажлын хэсгийн гол даалгавар гэж ойлгож байгаа.

Тэгээд энэ ажлыг нэлээн хугацаа зараад хангалттай хийсэн учраас одоо ер нь дүгнэлтээ сонсоод, тогтоолын төсөл рүүгээ орох, тэгээд өргөн барих шаардлагатай гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгье ээ тэгье. Тэгээд тогтоолын төслөө ажлын хэсгээс төслийг нь оруулж ирээд хоёр Байнгын хорооноос чуулгадаа оруулах, дараагийн хуралдаанд орох нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Тэгэхдээ энэ инженерчлэлийг энэ ажлын хэсэг хийхгүй шүү дээ. Энд Засгийн газар маш том баг гаргах ёстой гэж ойлгож байгаа. Маш том баг гаргах ёстой.

Тэгээд би түрүүн хэлсэн бараг Үндсэн хуульд магадгүй хүрэх ч асуудал гарч байж магадгүй. Тэгээд Засгийн газар нь ямар бүтэцтэй байх юм, Улсын Их Хурал ямар байдалтай байх юм гээд бүх асуудлуудыг томоор нь харах нь зүйтэй юм байна гэж харж байгаа шүү.

Ингээд төрийн байгууллагууд маань энэ өнцгөөс бас өөрсдийгөө хараарай. Доор дороо гаргасан юман дээрээ, тайлан дүгнэлт дээрээ бас нэг дүгнэлт гаргах хэрэгтэй байх. Тэгээд Улсын Их Хурлаас гарах тогтоолын төслийн дагуу л та бүхэн маань том баг болж л ажиллах нь зүйтэй байх л гэж харж байгаа шүү.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Төрийн байгуулалтын байнгын хороо болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хамтарсан хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 15 цаг 28 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД